ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

я

# ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 05 Улаанбаатар хот

| № | СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН ҮНДЭСЛЭЖ БАЙГАА БУСАД БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ | ТӨСӨВ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | СУУРЬ ТҮВШИН | ЗОРИЛТОТ ТҮВШИН | БИЕЛЭЛТ |
|---|---|---|---|---|---|---|
| Монгол улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.6, 2.2.7, 2.2.8 дэх заалт, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.2, 2.1, 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.1.4, 2.1.5, дэх заалт, Нийслэлийг 2021 -2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2020 -2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1, 2.1.2.1, 2.2.4, 2.2.3, 2.2.2, 2.2.9 -3.4. дахь заалт. | | | | | | |
| НЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | |
| Зорилт 1.1 Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна /НЗДҮАХ-1.1.1, ДЗДҮАМХ2.2.2, 2.3.1/ | | | | | | |
| 1.1.1 | Томуугийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх, томуугийн тархалтын түвшингийн үе шат бүрт тохирсон хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллана. | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | Биелэлт 90% | Биелэлт 91% | Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам, заавар батлах” А/373, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 9 сарын 14-ний “Төлөвлөгөө батлах тухай” А/1070 захирамж, НЭМГ-ын даргын 2023 оны 9 сарын 19-ний “Томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай” А/129 тушаалыг үндэслэн “Томуу томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, идэвхижил, дэгдэлтийн үед 2023-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г 3 чиглэл, 54 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын “Төлөвлөгөө батлах тухай” А/1070 захирамжийн хэрэгжилтийн явцад Нийслэлийн эрүүл мэндийн газрын А/160 тушаалаар батлагдсан удирдамж, шалгуураар үнэлгээ хийж, төлөвлөгөөний хэрэгжилт 92% хангалттай үнэлгээ авсан. |
| 1.1.2 | Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдалтай уялдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | Төсөв шаардахгүй | Хэрэгжилтийн хувь | Биелэлт 90.5% | Биелэлт 92% | Эрүүл мэндийн төв 2023 оны Гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг газар хөдлөлтийн үед нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд үндэслэн боловсруулж нийт 200 эмч, эмнэлгийн ажилтны томилгоо хийж, эм, эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөц хангалт, хээрийн эмнэлгийн 2 асар, түр байранд 100 ор дэлгэх тооцоог гарган ажилласан. Нэгдсэн эмнэлэг шаардлагатай эмийн 2-3 сарын нөөц бүрдүүлсэн. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийж, халдварын сэжиг илрэх үед авах арга хэмжээг цаг тухай бүрд авч хэрэгжүүлж байна. 2023 онд Тарваган тахал болон хүн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дархлаажуулалтын арга хэмжээ улсын хэмжээнд хийгдэхгүй байгаа тул урьдчилан сэргийлэх арга хэмжээний дагуу Төвийн даргын А/55 тоот тушаалаар 9 асуудлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Одоогийн байдлаар төлөвлөгөө 95 хувийн хэрэгжилтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Коронавируст халдварын шинэ дэд хувилбараар үүсгэгдсэн өвчлөл оношлогдсонтой холбогдуулан коронавируст халдвар (Ковид-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид болон амбулаториор үйлчлүүлэгчид, эмч ажилчдын дунд эмнэл-зүйн тандалтыг хийж халдварын тархалтаас сэргийлж ажиллаж байна. 2023 оны 4-р сараас коронавируст халдвар (Ковид-19)-ын халдварын тохиолдлын мэдээллийг өдөр тутам авч нэгтгэн Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэст 2023 оны 6-р сар хүртэл хүргүүлэн ажилласан. 2023 оны 7-р сараас Эрүүл мэндийн сайдын А/373 тоот тушаалаар томуугийн мэдээллийн системийг коронавируст халдвар (Ковид-19)-ын цахим программтай үе шаттай нэгтгэх журмын дагуу нэгтгэн томуугийн мэдээтэй хамт мэдээлж байна. Тандалтаар нийт 456 тохиолдол түргэвчилсэн тестээр илэрч, оношлогдон эмчлүүлсэн. |
| 1.1.3 | Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна | Улсын төсөв | Хамрагдсан иргэдийн тоо | Сургалтад 26356 иргэн хамрагдсан. | Сургалтад 27000 иргэн хамруулна. | Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх чиглэлээр иргэдэд зориулсан 10 төрлийн зөвлөгөө мэдээллийг боловсруулан эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвийн цахим хуудсанд байршуулж, нийт 21000 иргэнд хүргэн хандалтыг авсан байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.1.4 | ЭМС-ын 2022 оны А/528 тушаалаар баталсан Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана | Улсын төсөв | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт 91% | Төлөвлөгөөний хэрэгжилт 93% | ЭМС-ын 2022 оны А/528 тушаалаар баталсан Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг 7 зорилт 14 үйл ажиллагааны чиглэлээр боловсруулан ЭМТ-ын даргаар батлуулан ажиллаж байна. 2023 оны байдлаар хэрэгжилт 93%-тай байна. |
| Зорилт 1.2. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин эмгэг, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг тандах , урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх замаар нас баралтын хувийг бууруулна./ НЗДҮАХ-2.1.1, ДЗДҮАМХ2.2.2/ | | | | | | |
| 1.2.1 | Зонхилон тохиолдох халдварт бус өвчний (Хөх, умайн хүзүүний хорт хавдар, ЧШ, АГ ихсэх өвчин) - эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Гүйцэтгэлийн төсөв | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | АД-89.1% ЧШ-78.8% ХӨХ-78% УХ-41% | АД-90% ЧШ-79% ХӨХ-78.5% УХ-41.5% | 2023 оны эхний 10 сарын байдлаар Хан-Уул дүүргийн хэмжээнд халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамрагдвал зохих 18-аас дээш насны нийт 143574 иргэн амаас эрэгтэй 64631, эмэгтэй 78943 байна. Үүнээс; .<br>-Артерийн даралт ихсэх өвний эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд 104971 иргэн буюу 72 % нь хамрагдсан, үүнээс: Эрэгтэй 40791 буюу 38.8%, Эмэгтэй 64180 буюу 61.2 %, эдгээр үзлэгээс давтан үзлэгт нийт 24699 иргэн хамрагдсанаас шинээр артерийн даралт ихсэн өвчин 199 оношлогдсон байна.<br>-"Чихрийн шижин, хэв шинж-2" эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 35-аас дээш насны 89860 иргэн амаас эрэгтэй 40021, эмэгтэй 49839 байгаагаас үзлэг оношилгоонд 83605 иргэн буюу 93% нь хамрагдсанаас эрэгтэй 32531 буюу 38.9%, эмэгтэй 51074 буюу 61.1% нь хамрагдаж, , давтан үзлэгт 10303 иргэн орсноос шинээр чихрийн шижинтэй 26 иргэн оношлогдож эмчийн хяналтанд байна.<br>-Умайн хүзүүний /3 жилийн давтамжтай / эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд зорилтот насны хамрагдвал зохих 30-аас 60 ба түүнээс дээш 14301 зорилтот насны эмэгтэйчүүд хамрагдахаас 7100 эмэгтэй буюу 50% нь хамрагдсан.<br>-Хөхний үзлэг оношилгоонд хамрагдвал зохих 20-оос дээш зорилтот насны 58138 эмэгтэйгээс 49644 иргэн буюу 85%-ийн хамрагдалттай байна.<br>2. 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 209,524 иргэн хамрагдахаас 116,078 иргэн буюу 55.4 хувийн хамрагдалттай, Нийслэлийн хэмжээнд 2-дугаар байранд явж байна. Насны бүлгээр задалж үзвэл: 0-5 насны хамрагдвал зохих 25406 хүүхэд, хамрагдсан 20858 хүүхэд буюу 82.1 хувьтай, 6-17 нас хамрагдвал зохих 55537 хүүхэд, хамрагдсан 43468 хүүхэд буюу 78.2 хувьтай, 18-30 нас хамрагдвал зохих 31 404 иргэнээс, хамрагдсан 7795 иргэн буюу 24.8 хувьтай, 31-45 нас хамрагдвал зохих 53615 иргэнээс хамрагдсан 18 146 иргэн буюу 33.8 хувьтай, 46-60 нас хамрагдвал зохих 29139 иргэнээс шинжилгээнд хамрагдсан 15 504 иргэн буюу 53.2 хувьтай, 61-ээс дээш нас хамрагдвал зохих 14423 иргэнээс 10307 иргэн хамрагдсан буюу 71.5 хувийн хамрагдалтай байна. |
| 1.2.2 | Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад хүн амын мэдлэг хандлагыг сайжруулахад чиглэсэн сурталчилгааны материалыг цахимаар болон цаасан хэлбэрээр түгээнэ | 500,000 | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт 90% | Хэрэгжилт 91% | Хан-Уул эрүүл мэндийн төвийн цахим хуудсанд / https://www.facebook.com/khuemt.hospital /<br>2023 оны эхний 11 сарын байдлаар Халдварт бус өвчний талаар 69 төрлийн мэдээлэл, зөвлөмжид 81967 иргэн, Халдвар өвчний талаар 58 төрлийн мэдээлэлд 91521 иргэн, Эх хүүхэд, нөхөн үржихүйн 15 төрлийн мэдээлэлд 20698 иргэн, Эрүүл мэндийн даатгалын, баярын өдрүүдэд ажиллах цагийн хуваарь зэрэг цагийн үеийн асуудлаарх 6 төрлийн мэдээлэлд мэдээлэлд 21510 иргэн хандсан. Нийт 148 төрлийн мэдээлэл, зөвлөмжид 215969 иргэн хандсан байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.2.3 | Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт, үнэлгээг удирдамжийн дагуу зохион байгуулна | Төсөв шаардахгүй | Хэрэгжилт хувь | Удирдамжийн хэрэгжилт 94 % | Удирдамжийн хэрэгжилт 94,5 % | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор ажил мэргэжлийн уралдаан 1, аян 3 - Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг сайжруулъя 6 сарын аян, сувилагчийн чадвар-бидний бахархал 14 хоногийн аян, "Үйлчлүүлэгчдийн дуу хоолойг сонсоё" аян , тохиолдолд суурилсан хэлэлцүүлэг 4, чанарын алба, чанарын багаас чанарын дотоод сургалт 16 удаа, шинэ ажилтанг сургах сургалт 19 ажилтанд, ажлын байран дахь зөвлөгөө сургалт Эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр зөвлөмж 2, эмийн аюулгүй байдлыг сайжруулах зөвлөмж 2, эмч нарын өвчний түүх, яаралтай тусламжийн хуудас бичилт 12, ЦЦБ-ний аюулгүй байдлыг сайжруулах 1 сарын төлөвлөгөөт ажил, шинэ сувилагчийг сургах дадлага сургуулилт 7, ижил мэргэжилтний үнэлгээ 11 удаа /96,3%/хийж, нийт давхардсан тоогоор 1018 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилчид хамрагдсан. Бусад байгууллагаас чанарын сургалт 24 удаа зохион байгуулагдаж, 75 эмч, ажилчид хамрагдаж, мэдлэг ур чадвараа ахиулсан байна. Чанарын алба, сувилахуйн алба, нөхөн үржихүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, хүүхдийн мэргэжилтэн, халдвар судлаач нар удирдамжийн дагуу өрхийн эрүүл мэндийн төвүүдээр нийт 3 удаагийн дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжийг өгч ажилласан. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн халдварын сэргийлэлт хяналт, халдварт өвчний тандалт, хариу арга хэмжээнд хамтарсан хяналт тандалтыг 1 удаа хийж мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. ӨЭМТ-ийн дархлаажуулалтын цэгүүдээр дэмжлэгт хяналтыг 4 удаа хийсэн. 1-р дэмжлэгт хяналтын дундаж оноо 30 /90%/, 2-р дэмжлэгт хяналт: Эрүүл мэндийн сайдын 2023 оны "Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай" А/180, "Улаанбурхан, Улаанууд өвчний эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах тухай" А/188 дугаар тушаал, Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын даргын А/75 тоот, Эрүүл мэндийн төвийн даргын А/41 тоот тушаалуудын дагуу дэмжлэгт хяналт хийлээ. Вакцин аюулгүй байдал: Хангалттай 14 цэг, Хангалтгүй 2 цэг, Вакцин тарих арга техник: Хангалттай үнэлэгдсэн 11 цэг, Хангалтгүй 5 цэг, 3-р дэмжлэгт хяналт: ЭМТ-ийн даргын 2023 оны 09 сарын 07-ны өдрийн "Дархлаажуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай" А/58 тушаалын дагуу дэмжлэгт хяналт хийсэн. нийт оноо: 31 /88,7%/, 4-р дэмжлэгт хяналт: ЭМС-ын А/358, НЭМГ-ын А/149, ЭМТ-ийн даргын А/64 тушаалын дагуу Томуугийн дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийсэн. Үнэлгээ: Хангалттай. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын албанаас НИЙСЛЭЛИЙН эрүүл мэндийн газрын 591 дүгээр албан даалгавар, Эрүүл мэндийн төвийн даргын А/35 дугаар тушаалын хэрэгжилтэд, дархлаажуулалтын А/58 дугаар тушаал, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2163 дугаар зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт хийж, 2 зөвлөмжийн биелэлтийн тайланг НЭМГ хүргэсэн. Хагас болон бүтэн жилээрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээний биелэлтийг удирдамжийн дагуу үнэлж, үнэлгээ дүгнэлтийг Нийслэлийн эрүүл мэндийн газар болон дүүрэгт хүргүүлсэн байна. |
| Зорилт 1.3 Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна. /НЗДҮАХ-2.1.2, ДЗДҮАМХ2.2.2/ | | | | | | |
| 1.3.1 | Эрсдэлт бүлгийн хүн амын дунд болон хавьтлуудын дунд сүрьеэгийн идэвхтэй эрт ирлүүлэг үзлэгийг зохион байгуулж эмчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх | Улсын төсөв | Эрт илрүүлэгт хамрагдалтын хувь, Эмчилгээний амжилтын хувь | Эрт илрүүлэгт хамрагдалт -23 %, Эмчилгээний амжилт-85,7% | Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийн хувийг өмнөх оны мөн үеэс 0,1 %-иар нэмэгдүүлнэ, Эмчилгээний амжилтын хувь 86% | 2023 оны байдлаар 11014 хүнд үзлэг хийж, дараах оношилгоо, шинжилгээнд хамрууллаа. Үүнд:Амбулаторийн үзлэг 3389, Диспансерийн үзлэг 1962, Урьдчилан сэргийлэх үзлэг 6612, дуудлага-3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн урьдчилан Сэргийлэх үзлэгийг дотор задалж үзвэл рентген шинжилгээнд 4826 иргэн, Түрхэцийн шинжилгээнд 927 иргэн, үүнээс шинэ түрхэц зерэг гарсан 91, G-Xpert-ийн шинжилгээнд орсон 674 иргэн , Туберкулины сорил тавьсан 185 иргэн , үүнээс хэт өндөр урвалтай 51 хүн байна. Дээрх үзлэг шинжилгээнээс шинэ сүрьеэтэй-124, дахилт 14, шилжиж ирсэн 4, бусад 8, эмэнд тэсвэртэй сүрьеэ 13, нийт 168 тохиолдлыг эмчилгээнд хамруулан эмчилгээг 6-8 сар хяналттай хийж байна. 124 шинэ сүрьеэгийн тохиолдол илрүүлж эмчилгээнд хамруулсан нь 10000 хүн амд 5.5 промил байна. Энэ нь 2022 онтой харьцуулахад 4 тохиолдол, 0,8 промилээр буурсан байна.Хяналтанд орж эмчлэгдэж байгаа 168 өвчтөний хавьтал 328 хүнийг шинжилгээнд хамруулан 68 хавьтлыг далд халдварын эмчилгээнд хамруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 дахин өссөн байна. Индекс тохиолдлын хавьтлын үзлэгт хамрагдалтын хувь 90% байна. Солонгосын үндэсний сүрьеэгийн Нийгэмлэг /СҮСН/-тэй хамтран зөөврийн рентген аппараттай автобустай баг болон гэрээр явуулын баг эмнэлэгт очиж үйлчлүүлэх боломжгүй хэвтрийн иргэд, 2020-2023 онд бүртгэгдсэн сүрьеэгийн өрхийн хавьтлын илрүүлэг үзлэгийг 26 удаа зохион байгуулж 651 хүн хамрагдсан бөгөөд сэжигтэй 54 тохиолдлыг цэрний шинжилгээнд хамруулж, нян судлалаар батлагдсан 4, эмнэлзүйгээр 3 тохиолдлыг эмчилгээнд хамруулсан. Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоотой хамтран сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амыг илрүүлэг, үзлэг шинжилгээнд 2097 иргэнийг хамруулан сүрьеэтэй байж болзошгүй 46 иргэнийг цэрний түрхэцийн болон жене эксперт шинжилгээнд хамруулж, нян судлалаар батлагдсан 7, эмнэлзүйгээр 2 тохиолдлыг эмчилгээнд хамруулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.3.2 | ЭМС-ын 2022 оны А/528 тушаалаар баталсан Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах | Улсын төсөв | Төлөвлө-гөөний хэрэгжил-тийн хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт 93% | Төлөвлөгөөний хэрэгжилт 94% | ЭМС-ын 2022 оны А/528 тушаалаар баталсан Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг 7 зорилт 14 үйл ажиллагааны чиглэлээр боловсруулан ЭМТ-ын даргаар батлуулан ажиллаж байна. 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 94.5 %-тай хэрэгжилттэй байна. |
| 1.3.3 | Бэлгийн замаар дамжих халдварын идэвхтэй тандалт, эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрсдэлт бүлгийн иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор аян зохион байгуулах, их, дээд болон ЕБС-ийн эмч нарт сургалт, сурталчилгааг зохион байгуулах, иргэдэд зориулсан мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах | Төсөв шаардахгүй | Идэвхтэй тандалтын илрүүлэл-тийн хувь | 12255 иргэн хамрагдахаас 6127 иргэн хамрагдаж 51 % буюу Эмчилгээнд хамрагдалт 100% | Өмнөх оны мөн үеэс 0,5 хувиар нэмэгдүүлнэ.Эмчилгээнд хамрагдалт 100% | 2023 оны байдлаар статистик тоон мэдээгээр Бэлгийн замаар дамжих халдварт өвчин/ДОХ -ын кабинетээр нийт 29373 иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн байна.<br>-Нийт үзлэг -29373<br>-Диспансерийн хяналт -2223<br>-Урьдчилан сэргийлэх үзлэг -19032<br>-Амбулаторын үзлэг-8115<br>-Дуудлага-3<br>-Идэвхитэй эрт илрүүлэг-15335<br>Бэлгийн замаар дамжих халдварийн шинэ 157 тохиолдол илэрсэн ба үүнээс Тэмбүү өвчин -103 /жирэмсэн 27/, Заг хүйтэн-41, Трихомониаз-13 байна. Эдгээр шинэ тохиолдлыг хяналтанд авч 100% эрүүлжүүлсэн. 2023 оны байдлаар 157 шинэ өвчлөлийн тохиолдол илэрч эрүүлжүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бэлгийн замаар дамжих халдварт өвчин 58 тохиолдлоор буюу 2.1 промилоор өссөн үзүүлэлттэй байна.<br>Бэлгийн замаар дамжих халдварын кабинетаас:<br>-Хан-Уул дүүргийн 15 Өрхийн Эрүүл мэндийн төвийн 142 эмч, сувилагчдад БЗДХ-ийн кабинетаас мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт үнэлгээ хийсэн. Эрсдэлт бүлгийн 32 иргэдэд Бэлгийн замын халдвараас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа хийсэн.<br>-Хан-Уул дүүргийн харьяа ЕБС, монгол солонгосын политехникийн коллеж, механик инженерийн сургууль, МСҮТ-ийн 20 сурагчдад нотолгоонд суурилсан эрүүл мэндийн боловсрол олгох "Үе тэнгийн сургагч багш" бэлтгэх сургалт зохион байгуулж батламж гардуулсан.<br>-"Зөрэг хандлага-Эрүүл оюутан" оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Харьяа их дээд сургууль, МСҮТ, коллежийн 249 оюутан сурагчдад Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа хийж, 253 оюутныг аяны хүрээнд Эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулсан. Үүнээс тэмбүүгийн 2 шинэ тохиолдол батлагдаж эрүүлжүүлсэн.<br>-Нийслэлийн эрүүл мэндийн газрын А/1189 тоот тушаалын дагуу Бэлгийн замын халдвар, ХДХВ/ДОХ-оос иргэд олон нийтийг урьдчилан сэргийлэх, эрсдэлгүй зан үйл төлөвшүүлэх чиглэлээр ХУД-ын харьяа Их дээд сургууль, хүүхдийн байгууллагын 19 эмч нарт, 15 зочид буудлын эзэд, үүд баригч нарт сургалт сурталчилгаа хийсэн.<br>-ХУД-ийн 14-р хороонд орших Өлзийт асар ТББ-ийн байранд ХУД-ын цагдаагийн хэлтэс, Хан-Уул улаан загалмайн хороо, ХУД цагдаагийн хэлтэстэй хамтран ХУД-ийн орон гэргүй 76 иргэдийн дунд эрүүл мэндийн идэвхитэй эрт илрүүлэг хийсэн. Үүнээс тэмбүүгийн 23 зөрэг тохиолдол гарсан. Үүнээс шинэ 2 тохиолдол батлагдаж эрүүлжүүлсэн. |
| 1.3.4 | Товлолт болон товлолт бус дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлж тарилгатай халдварт өвчнөөс сэргийлэх | | хамрагдалт хувиар | 98% | 98% | 2023 оны эхний 10 сарын байдлаар халдварт өвчний товлолт дархлаажуулалтын хамралт вакцин тус бүрээр: Халдварт саагийн вакцины бүрэн тунд 4580 хүүхдээс 4569 /99.7%/, тавт вакцины бүрэн тунд 4575 хүүхдээс 4564 /99.7%/, /Давхардсан тоогоор саагийн вакцины 1-4 дүгээр тунд нийт 18349 хүүхдээс 18304 /99.7%/, тавт вакцины 1-3 дугаар тунд нийт 13886 хүүхдээс 13854 /99.7%/ хүүхэд хамрагдсан./, улаанбурхан, гахай хавдар, улаанууд /УГУ/-ын эсрэг вакцины бүрэн тунд 4040 хүүхдээс 4001 /99.0%/, А-гепатитын вакцины бүрэн тунд 4017 хүүхдээс 3978 /99.0%/, Пневмококкийн эсрэг вакцины бүрэн тунд 4114 хүүхдээс 4091 /99.4%/, Сахуу татрангийн вакцины бүрэн тунд 3520 хүүхдээс 3510 /99.7%/хүүхэд тус тус хамрагдсан. Товлолт дархлаажуулалтанд давхардсан тоогоор 70330 хүүхэд хамрагдахаас 70063 хүүхэд хамрагдаж, хамралтын хувь 99.6% байна. Тархвар судлалын заалтаар галзуу, эрүүл мэндийн ажилтнуудын гепатитын В, хачигт энцефалитын, ковидын, томуугийн вакцин, нэмэлтээр улаанбурхан улаанууд, сайн дураар иргэдэд гепатит В-ын эсрэг вакцин хийж байна. Үүнд: Галзуугийн вакцинд-908/908-100%, Хачигт энцефалит-39/39-100%, Онцгой байдлын хэлтсийн албан хаагчид, Томуугийн вакцин-21990/19340-88%, В гепатит /ЭМА/ -100/100-100%, УУ нэмэлт- 10 сараас 8 нас хүртэл 44985 хүүхдээс 16773 хүүхэд хамрагдаж хамралтын хувь 37.3%, Сайн дурын дархлаажуулалт: В гепатит 1-3-р тун /Иргэд/ -1825/1825-100%, “Ковид-19” халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 1-р тунд 15, 2-р тунд 24, 3-р тунд 87, 4-р тунд 27, 5-р тунд 4 иргэн, нийт-157 иргэнийг хамруулсан. |
| Зорилт 1.4. Гэр бүлийн гишүүн бүрд эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох ажлыг шат дараатай хийнэ./ НЗДҮАХ 2.1.4, ДЗДҮАМХ2.2.1, 2.2.3/ | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.4.1 | Олон нийтийн цахим сүлжээ, цахим орчин, хэвлэл мэдээллэлийн хэрэгслээр иргэдэд хүргэх урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэлийг Хан-Уул ЭМТ-н вэбсайт, албан ёсны цахим хуудас, Дүүргийн шуурхай штабын пэйж хуудас, фасебүүк хаягаар мэдээллийг иргэдэд шуурхай, үнэн зөв хүргэж ажиллах | Төсөв шаардахгүй | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт 95% | Үйл ажиллагааны хэрэгжилт 95% | Төрийн албаны вэбсайтны стандарт MNS 6285:2017 баримт бичигт тусгагдсан өөрчлөлт нь энэ стандартыг баримтлан 2017-оос 2023 онуудад удаа дараа шинэчилж ирсэн. Монгол Улсын Засгийн газрын 201 дүгээр тогтоолоор батлагдсан Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмын дагуу тайлан мэдээг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.<br>Хан-Уул эрүүл мэндийн төвийн нэгдсэн huemt.ub.gov.mn, huemn.ub.gov.mn домэйн нэр бүхий вэбсайт сайтуудыг хөтлөж ирсэн бөгөөд 164 мэдээ байршуулж 48700 хандалттай байна. Мөн сошиал эрүүл мэндийн төвийн 23580 дагагчтай хуудас болон Эрүүл мэндийг дэмжих төвийн 2586 дагагчтай хуудсуудаар мэдээлэл түгээдэг бөгөөд Эрүүл мэндийн төв 5000 найзтай аккаунт ашиглаж мэдээлэл түгээж хэвшсэн. |
| | ЗГ-ын 224-р тогтоолыг хэрэгжүүлэн, эрүүл мэндийг | | | | | НЭМГазрын 2023 оны А/10 дугаар батлагдсан "Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шинэ зохион байгуулалтыг хэрэгжүүлэх тухай" тушаалын 4 хавсралтын 58 заалтыг хэрэгжүүлж ажилласан.<br>2023 оны эхний 11 сарын байдлаар Халдварт бус өвчний талаар 69 төрлийн мэдээлэл, зөвлөмжид 81967 иргэн, Халдвар өвчний талаар 58 төрлийн мэдээлэлд 91521 иргэн, Эх хүүхэд, нөхөн үржихүйн 15 төрлийн мэдээлэлд 20698 иргэн, Эрүүл мэндийн даатгалын, баярын өдрүүдэд ажиллах цагийн хуваарь зэрэг цагийн үеийн асуудлаарх 6 төрлийн мэдээлэлд мэдээлэлд 21510 иргэн хандсан. Нийт 148 төрлийн мэдээлэл, зөвлөмжид 215969 иргэн хандсан байна.<br>1. Эрүүл мэндийн төвийн цахим хуудсанд бага насны хүүхдийг ахуйн осол гэмтлээс сэргийлэх талаар зурагт хуудас байршуулж, 6339 хүний, зам тээврийн ослоос сэргийлэх талаарх хуудас байршуулж, 1134 хүний хандалт авсан байна.<br>Өрхийн эрүүл мэндийн төвүүд "Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх" сэдвээр 42 удаагийн сургалтаар 1872 иргэнд, 35 төрлийн брошураар 6381 хүнд, цахим хандалтаар 2814 хүнд хүрсэн.<br>2. Эрүүл мэндийн төвийн цахим хуудсанд "Архины хор уршиг"-ийн талаарх зурагт хуудас байршуулж, 2954 хүн хандсан. ӨЭМТөвүүд Архины хор уршиг 24 удаагийн сургалтаар 570 хүнд, 25 төрлийн брошураар 2815 хүнд, цахим хандалт 1660 авсан.<br>3. Урологийн эмч С.Дүйнхэржав Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаар зөвлөмж, бичлэг бэлтгэн эрүүл мэндийн төвийн цахим хуудсан байршуулсан. Хандсан хүний тоо 3542. Эрчүүдэд чиглэсэн амьдралын зөв дадал бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор эрчүүдийг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтад 49 хүн хамрагдсан, зөвлөгөө, мэдээлэлийг 326 хүнд өгсөн. Цахим хандалт 1333<br>4. Сүрьеэтэй тэмцэх 4 өдөрлөг 3 сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Өдөрлөгт нийт 620 иргэн оролцож зөвлөмж, мэдээлэл авсан. Сүрьеэ өвчний талаарх зурагт хуудсыг эрүүл мэндийн төвийн цахим хуудсанд байршуулсан 2452 хүний хандалт авсан байна.<br>5. Хавдрын эрт үеийн шинж тэмдэг болон анхдагч эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх асуудлаар мэдээлэл, сургалт, сурталчилгааг иргэдэд хүргэх зорилгоор Монголын үндэсний олон нийтийн телевизийн өглөө |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.4.2 | дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. | 1 сая | Тайлангийн хэрэгжилтийн хувь | Тайлангийн хэрэгжилт 93% | Тайлангийн хэрэгжилт 95% | хөтөлбөрт хавдрын эмч Ц.Цэцэгмаа 2023.03.30-ний өдөр зочноор оролцон "Хавдрын эрт үеийн шинж тэмдэг болон анхдагч эрсдэлт хүчин зүйл"-ээс урьдчилан сэргийлэх талаар иргэдэд мэдээлэл хүргэсэн. Мөн 12 удаагийн танхимын сургалтаар 346 иргэнийг, өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй 131 иргэнд мэдээлэл, зөвлөгөөгөөр, 3439 иргэд цахим хандалтаар мэдээлэл өгч ажилласан байна.<br>3 сарын 28, 31-нд Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны хавдартай иргэдэд Олон нийтийн шим тэжээл ТББ-тай хамтран хоолзүйн сургалт зохион байгуулж нийт 8 хавдартай иргэнийг хамруулсан.<br>6. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх чиглэлээр Хан-Уул Эрүүл мэндийн төв болон ӨЭМТ-үүдийн цахим хуудсаар тогтмол мэдээ мэдээлэл зөвлөмж өгч ажиллаж байна. Хандсан хүний тоо 8255. Улаанбурхан, салхинцэцэг өвчнөөс сэргийлэх зурагт хуудсанд хандсан хүний тоо 4353, мөн сэдвээр 4000 зурагт хуудас, гарын авлага хэвлүүлж, тараасан.<br>7.Дэлхийн тамхигүй өдрийн хүрээнд Эрүүл мэндийн төв нь цахим хандалтаар нийт 8621 хүнд, 198 хүнд мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүд нийт 33 сургалтаар 1425 хүнд, цахимаар 1406 хүнд, мэдээлэл, зөвлөгөөгөөр 660 хүнд Тамхины хор уршиг, тамхинаас татгалзах талаар мэдээлэл хүргэж ажилласан байна.<br>8. 2023 оны 4 сарын 26, 27-ны өдрүүдэд Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан "Нийгмийн салбарын өдөрлөг"-т халдварт бус өвчний эрт илрүүлэг сэдвийн хүрээнд Эрүүл мэндийн төвийн дотоод шүүрлийн кабинетын эмч сувилагч болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хамтарсан баг иргэдэд үзлэг, шинжилгээ, зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажилласан. Өдөрлөгөөр артерийн даралт 140 хүнд, сахарын тест 137 хүнд үзэж, халдварт бус өвчнөөс сэргийлэх болон эрт илрүүлгийн насны багцын мэдээлэл бүхий 12 төрлийн гарын авлага 488 иргэнд тарааж, зөвлөгөө өгсөн.<br>9. 2023 оны 5 сарын 31-нд Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулсан "Эрүүл Монгол хүн" фестивальд Эрүүл мэндийн төвийн болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хамтарсан баг 90 хүнд танита аппаратаар хэмжилт хийж, артерийн даралт үзэж, хооллолтын гэр зөвлөмжөөр зөвлөгөө өгсөн.<br>10. 2023 оны 6 сарын 4-ны өдөр Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Бүтээгч Хан-Уулчууд" өдөрлөгөөр нийт 1037 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, 3200 гаруй хүнд брошур, тараах материалаар халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргэж, 2 мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгсөн. |
| 1.4.3 | Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд ЭМТ-ийн "Эрүүл ээж, Эрүүл удам" цахим хаяг, пэйж хуудас, Хан-Уул Эко дүүргийн фэйсбүүк хаягаар "Гэр бүл төлөвлөлт, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл"-ийн талаар мэдлэг, мэдээлэл олгох ажлыг эрчимжүүлж ажиллах | Төсөв шаардахгүй | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт 95% | Үйл ажиллагааны хэрэгжилт 97% | 2023 оны эхний 11 сарын байдлаар 25 хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн бүртгэл судалгаанд 15-49 насны нийт 61126 эмэгтэй байна.<br>• эрсдэлт бүлэг-2157<br>• эмзэг бүлэг-1503<br>• хөгжлийн бэрхшээлтэй-272 буюу зорилтот бүлэг нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 6.4%-г эзэлж байна. эдгээр эмэгтэйчүүдийн 27506 /45%/-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.Эрсдэлт, эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн 2569/70%/-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан ба 2525 /69% / нь жирэмснээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж байна.<br>Эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран дүүргийн үйлчлэх хүрээний зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд "Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулья" сэдэвт 6 сарын аяны хүрээнд "Эрүүл ээж, Эрүүл удам" цахим хаяг, пэйж хуудас, Хан-Уул Эко дүүргийн фэйсбүүк хаягаар "Гэр бүл төлөвлөлт, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл"-ийн талаар тогтмол мэдээлэл хүргэсэн. Хандалтын тоо 2156.<br>Аяны хүрээнд зорилтот бүлгийн 960 эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлт, жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийн талаар бэлтгэсэн 5 төрлийн гарын авлага тараасан. |
| 1.4.4 | Өсвөр үе, залуусын дунд хар тамхи, мансууруулах бодисын хор уршгаас сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт 91% | Үйл ажиллагааны хэрэгжилт 93% | 2023 оны байдлаар "Мансууруулах бодисын хор хөнөөл" сургалтыг Монгол билиг оюу, 115, 7, 15, 32, 34, 52-р сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад, Монгол Солонгосын Коллеж, ШУТИС-н харьяа Механик инженерын ДС, МСҮТ-ийн 11 удаагийн сургалтанд 786 хүүхэд залуус хамрагдсан байна. Өсвөр насны 6235 хүүхэд залууст хар тамхи, мансууруулах бодисын хор уршгаас сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг явуулсан.<br>Аддиктологийн төвөөс зохион байгуулсан "Электрон тамхигүй-Эрүүл ирээдүй" аяны хүрээнд утаагүй тамхи татах нь мода (соёл) биш сэдвээр бэлтгэсэн зурагт хуудсыг Хан-Уул эрүүл мэндийн төвийн цахим хуудсанд байршуулан иргэдэд мэдээлэл, сурталчилгааг хүргэсэн ба хандалт авсан иргэний тоо 1722 байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.4.5 | Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет бий болгох | Улсын төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт 0 | Төлөвлөгөөний хэрэгжилт 50% | Эрүүл мэндийн төвийн эрэгтэйчүүдийн кабинетийг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд мэс заслын 1 эмчийг урологийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх 6 сарын сургалтад хамруулж төгсөж 2023 оны 04 дүгээр сараас эрэгтэйчүүдийн үзлэг оношлогоог амбулаторид 147 иргэнд хийж, мэс засал хийлгэх болон онош тодруулах шаардлагатай 23 үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалд илгээн, эмийн эмчилгээ болон зөвлөгөө мэдээлэл өгөн ажиллаж байна. Мөн цэргийн насны залуучуудад урьдчилан сэргийлэх үзлэг хийж 46 үйлчлүүлэгч өвчтэй буюу мэс засал эмчилгээ хийлгэх шаардлагатай болохыг илрүүлсэн бөгөөд эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна., Эрүүл мэндийн төвийн дотор засварын ажил гүйцэтгэж байгаа Рок Гранд компанид эрэгтэйчүүдийн кабинетийг оруулах мэс заслын боолтын өрөөнд хана хийж, засвар хийлгэх саналаа өгсөн, Кабинетийн үйл ажиллагаанд шаардагдах 10 сая төгрөгний тоног, төхөөрөмж, бусад эмнэлгийн багаж хэрэгсэл, жагсаалт болон төслийн хамт Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ажлын албанд хүргүүлсэн. |
| 1.4.6 | Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч, сувилагч нарын ажлын байран дээр Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарыг чадавхжуулах ажлын байрны сургалтыг зохион байгуулна | Төсөв шаардахгүй | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт 85% | Үйл ажиллагааны хэрэгжилт 90% | Өрхийн эрүүл мэндийн төвд шинээр ажилд орж байгаа эмч, сувилагч нарыг чадавхижуулах чиглэлээр ЭМТ-н нарийн мэргэжлийн эмч нар болох хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн эмчийг дагалдуулан ажлын байран дээрх сургалтыг тогтмол зохион байгуулж нийт 5 эмч, 2 сувилагч эх барих эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн эмчийг ажлын байран дээр дагалдуулан гардан болон онолын сургалтад 7 хоног хамруулсан. |
| 1.4.7 | Өсвөр үеийн охидын дунд "Жирэмслэлтээс сэргийлэх, ДОХ/БЗДХӨ-өөс сэргийлэх" сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ | | Сургалтын тоо, Сургалтанд хамрагдсан хүүхдийн тоо | ӨҮО дунд "Жирэмслэлтээс сэргийлэх,ДОХ/ БЗДХӨ-өөс сэргийлэх" сургалт – 2удаа Хамрагдсан хүүхэд - 654 | Үйл ажиллагааны тайлан, хэрэгжилтийн хувь | 2023 оны 04 дүгээр сарын 04-07 өдрүүдэд Хан-уул дүүргийн цагдаагийн 1-р хэлтсийн өсвөр үеийн мэргэжилтэн, Хан-Уул Эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн эмч, Бэлгийн замаар дамжих халдварт өвчний кабинетийн эмч, Нөхөн үржихүйн зохицуулагч нар хамтран "МОНГОЛ БИЛЭГ ОЮУН", 115, 32, 15,18-р сургуулийн 9-12 дугаар ангийн 350 сурагчдад "Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт", "Жирэмснээс сэргийлэх аргууд", "Электрон тамхины хор уршиг", "Бэлгийн замаар дамжих халдварт өвчин гэж юу вэ", "Өсвөр үеийн тулгамдсан асуудал" сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.<br>2023.05.09-нд Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн алба, Дүүргийн Засаг даргын Тамгын газар, боловсролын хэлтэстэй хамтран өсвөр үеийн хүүхдүүд үе тэнгийн найз, нөхдөөрөө дамжуулан нотолгоонд суурилсан эрүүл мэндийн боловсрол, мэдлэгээ, мэдээллийг олгох зорилгоор "ҮЕ ТЭНГИЙН СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ" сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн 9-12 ангийн 80 сурагчдад сургалт зохион байгуулсан. Сургалтаар дараах ур, чадваруудыг эзэмшүүлэхээр зорьсон:<br>*Үе тэнгийн эрүүл мэндийн боловсролын чиглэлээр онол, арга зүйг эзэмших<br>* Эрүүл мэндийн боловсролыг үе тэнгийнхэндээ ойлгуулахад тоглоомын арга болон багаар хамтран ажиллах аргуудаар амжилттай явуулахад суралцах<br>* Нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замын халдвар, осол гэмтэл, хүчирхийлэл зэрэг сэдвээр ойлголтой болж, үе тэнгийнхэндээ үнэн зөв мэдээлэл дамжуулах чадварууд эзэмшсэн. Сургалтын өмнө болон дараах сорил авч дүгнэж үзэхэд өсвөр үеийнхний сургалтанд оролцсон хүүхдүүдийн мэдлэг 80%-иар дээшилж, бусдад сурсан зүйл мэдээлэл түгээх, өөртөө мэдээлэл авах эрмэлзэлэл ихтэй идэвхтэй оролцлоо.<br>Яармаг бүсэд: 4-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвөөс 34 сургуулийн 30 сурагчид 1 удаа, 5,6 хорооны өрхийн эрүүл мэндийн төвөөс 41р сургуулийн 534 сурагчдад 4 удаа, 8-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвөөс 118 сургуулийн 150 сурагчдад 1 удаа сургалт хийсэн.<br>Нисэх бүсэд: 9-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвөөс 114 сургуулийн 862 сурагчид 2 удаа, 7 хорооны өрхийн эрүүл мэндийн төвөөс 7-р сургуулийн 969 сурагчдад 2 удаа, 12-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвөөс 10-р сургуулийн 54 сурагчдад 3 удаа, 14-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвөөс 59р сургуулийн 210 сурагчид 2 удаа, 16-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвөөс 89-р сургуулийн 342 сурагчдад 2 удаа тус тус сургалт хийж, мэдлэг олгосон. |
| 1.4.8 | Дүүргийн НХХ, Боловсролын хэлтэстэй хамтран "ҮЕ ТЭНГИЙН СУРГАГЧ " бэлтгэж, үр дүнг тооцох | ДЗДТГ, Төсөл хөтөлбөр | ҮЕ ТЭНГИЙН СУРГАГЧ " -аар бэлтгэгдсэн хүүхдийн тоо, | ҮЕ ТЭНГИЙН СУРГАГЧ " 2022 онд бэлтгэгдээгүй | Үйл ажиллагааны тайлан | Өсвөр үеийнхний эрүүл мэндийн боловсролыг дэмжиж, өсвөр насны сэтгэлзүйн онцлог, эрүүл зөв хооллох, нөхөн үржихүй, осол гэмтэл, хүчирхийлэл, архи тамхины нөлөө болон бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр сайжруулах, үе тэнгийнхэндээ үнэн зөв мэдээлэл дамжуулахад дэмжлэг олгох зорилгоор Эрүүл мэндийн төв Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газар, боловсролын хэлтэстэй хамтран "Үе тэнгийн сургагч багш бэлтгэх" 2 удаагийн сургалтыг харьяа ерөнхий боловсролын 23 сургуулийн 80 сурагчийг хамруулан зохион байгуулсан. Сургалтын өмнөх тестийн сорил 37,3 оноо буюу 46% байсан бол сургалтын дараах тестийн сорил 57 оноо буюу 78% болж сурагчдын мэдлэг дээшилсэн байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.4.9 | Харшилгүй -Эрүүл дүүрэг" аян зохион байгуулж, эрүүл мэндийн зөвлөмжийг цахим орчинд байршуулан иргэдэд түгээнэ /ДЗДҮАМХ2.2.9/ | Улсын төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт 93% | Үйл ажиллагааны хэрэгжилт 93.5% | 2023 оны 5 сарын 16-ны өдөр өрхийн эрүүл мэндийн төвийн 13 эмч, Эрүүл мэндийн төвийн халдвартын 1 эмчийг хамруулан "Харшлын үед үзүүлэх тусламж үйлчилгээ" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Арьсны өвчин судлалын Үндэсний төвийн эмч Д.Мөнгөнтүлхүүр, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш Түвшинтөр нар "Харшлын өвчний эмгэг жам, оношилгоо, эмчилгээ, Арьс хаттах сорил, хийх арга техник, Харшил хөдлөх үед баримтлах дэглэм, Харшлын вакцин эмчилгээ" зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан. Харшилаас урьдчилан сэргийлье нугалбарыг 2000 ширхэг хэвлүүлэн, тараасан. ЭМТ-ийн цахим хуудсанд "Ургамлын тоосны харшлаас урьдчилан сэргийлэх" зурагт зөвлөмжийг байршуулж, 2201 хүн хандалт хийсэн байна. Мөн Шарилж, луулийн төрлийн ургамлыг хэрхэн зөв хадалт, тайралт хийх талаар бичлэг бэлтгэж, цахим хуудсанд байршуулсан. Хандсан хүний тоо 2963. Уг зөвлөмж бичлэгийг ЗДТГазрын Нийгмийн хөгжлийн хэлтэст илгээж, ургамлын хадалт, тайралтыг заавряын дагуу хийхийг зөвлөсөн. ӨЭМТ-үүд өөрсдийн цахим хаягаар дээрх зөвлөмжийг хүргэж ажилласан. Хандсан хүний тоо 1708. ӨЭМТөвүүд 22 удаагийн сургалтаар 771 иргэн хамруулж, 25 төрлийн брошураар 1024 иргэнд мэдээлэл хүргэж, 1934 цахим хандалт авсан байна. |
| 1.4.10 | Мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын хор уршгаас сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэхээр төлбөрийг төр даах эм олголтонд хяналт хийж, сургалтыг зохион байгуулна | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт 85% | Төлөвлөгөөний хэрэгжилт 86% | Эрүүл мэндийн Сайдын А/68 дугаар тушаалыг үндэслэн Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 сарын 18-ны өдрийн А/10 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан "Мансууруулах сэтгэц нөлөөт эмийн зохицуулах, хэрэглэх, устгах" журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 100%-ийн хэрэгжилттэй байна.<br>Төлбөрийг төр даах эмийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 01, 02 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын А/100 дугаар тушаалын дагуу мансууруулах сэтгэц нөлөөт 14 төрлийн эмийг 554 үйлчлүүлэгчдэд эмчийн жороор, Эрүүл мэндийн сайдын сангийн сайдын хамтарсан 2012 оны 129/100 тоот тушаалын дагуу төлбөрийг төр хариуцан олгох эмэнд нийт 39 хүнийг 12 удаагийн давтамжтай 28204 ширхэг эмийг эрүүл мэндийн төвийн мансууруулах сэтгэц нөлөөт эм хариуцдаг эм зүйчээс олгосон.<br>Монгол улсын Хар тамхитай тэмцэх алба, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан баг 2023 оны 4 сарын 13нд Эрүүл мэндийн төвийн эрчимт, хүлээн авах яаралтай тусламжийн тасаг, хэвтэн эмчлүүлэх, амбулаторийн тасгуудаар орж "Мансууруулах сэтгэц нөлөөт эмийн орлого, зарлага, захиалга олголт, хадгалалт, устгал" ын хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийсэн.<br>Мансууруулах сэтгэц нөлөөт эмийг олгодог клиник эм зүйч нь эрчимт эмчилгээ, дотор мэдрэл, гемодиалез, хөнгөвчлөх, хүлээн авах яаралтай тусламжийн тасгуудад өдөр тутам захиалга хийхдээ хяналт үнэлгээг тогтмол хийдэг. Эм зүйн албанаас улирапд 1 удаа бүх эмч сувилагч нарт жорын стандарт, эмийн гаж нөлөө сэдвээр давхардсан тоогоор 105 хүнд сургалт, сурталчилгаа хийсэн. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын албанаас мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн хяналтыг хүлээн авах яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, хими хөнгөвчлөх, амбулаторийн хавдрын кабинетэд 12 удаагийн хяналтыг хийж, арга зүйн зөвлөгөөг ажлын байран дээр 6 удаа давхардсан тоогоор 64 сувилагчид өгч, хүлээн авахын анхан шатны маягтыг Эрүүл мэндийн сайдын А/68 дугаар тушаалд зааснаар шинэчлэн эм тарианы орлого зарлагын бүртгэл хөтлөлт, хяналтыг сайжруулж, мансууруулах сэтгэц нөлөөт тарианы ампулыг өдөр бүр хүлээлцэн баталгаажуулсан. Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны А/07 дугаар тушаалаар Эмийн эмчилгээний зохицуулах хорооны журмыг шинэчлэн 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.Эмийн эмчилгээний зохицуулах хорооноос мансууруулах сэтгэц нөлөөт эмийн хор уршиг, түүнээс сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэгийг зурагт хуудсаар мэдээллийн самбарт байршуулж хор уршгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна. Төлбөрийг төр даах эмийг олгодог эм зүйч мансууруулах сэтгэц нөлөөт 14 нэр, төрлийн эм тариаг үйлчлүүлэгчдэд олгохдоо зөв танин тодруулж /иргэний үнэмлэх, эмчийн карт, эмчийн жор, хяналтын хуудсаар тулгалт хийж олгодог. |
| ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| Зорилт 2.1 Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлж чадавхжуулан, нийгмийн баталгаар хангана. /НЗДҮАХ 2.1.5, ДЗДҮАМХ | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн стратеги төлөвлөгөө, хүний нөөцийг хөгжүүлэх бодлогыг шинэчлэн боловсруулна | Төсөв шаардахгүй | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт 96% | Төлөвлөгөөний хэрэгжилт 96,5% | Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн стратеги төлөвлөгөөг хуулийн хүрээнд 4 бүлэг, 11 заалттайгаар шинэчлэн боловсруулж, Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон Дүүргийн Засаг Даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг болон эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, мэргэшлийг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг Төвийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг 2019-2023 онд хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хөтөлбөрийн хэрэгжилт 97%-тай хэрэгжиж байна. |
| 2.1.2 | Хүний нөөцийг 2019-2023 онд хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана. | Байгууллагын төсөв | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Хөтөлбөрийн хэрэгжилт 94% | Хөтөлбөрийн хэрэгжилт 95% | Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг 2019-2023 онд хөгжүүлэх хөтөлбөрийг төлөвлөгөөнд тусгасны дагуу эмч эмнэлгийн мэргэжилтэний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хан-Уул Эрүүл мэндийн төвийн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэл, Эрүүл мэндийн салбарын 2022-2023 оны хамтын хэлэлцээрийн нэгдүгээр зүйлийн 1.3, гуравдугаар зүйлийн 3.1, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 10 дугаар зүйлийн 10.2.3, Хамтын гэрээний 2 дугаар зүйлийн 2.12 дахь заалтын дагуу Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтнуудын цалинг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 20%-иар нэмэгдүүлэн олгож, мөн хуульд заасан журмын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, зэргийн нэмэгдэл, хүнд хортой нөхцлийн нэмэгдэл, бусад холбогдох нэмэгдлийг тогтмол олгон ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 97% тай хэрэгжиж байна.Мөн Хан-Уул Эрүүл мэндийн төвийн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэл, Үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээний 2 дугаар зүйлийн 2.12 дахь заалтын дагуу 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс Эрүүл мэндийн төвийн албан хаагчдын хоол унааны мөнгийг 25%-иар нэмэгдүүлэн олгож байна. Дэлхийн эмч нарын баярыг тохиолдуулан эмч, ажилчдын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулж 50.000-300.000 төгрөгийн мөнгөн урамшуулал олголоо. Мөн тархины цахилгаан бичлэгийн эмч, ХДХВ/ДОХ/БЗДХ- эмч төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж төгссөн. Сувилагч нарын баярыг угтан нийт сувилагч нар Монголын Үндэсний олон нийтийн телевизийн "Ном хож" танин мэдэхүйн нэвтрүүлэгт амжилттай оролцсон байна. |
| 2.1.3 | 1.Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт<br>2. Архив албан хэрэг хөтлөлийн ажилд мэдээллийн технологи нэвтрүүлэх<br>3. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа.<br>4. Байгууллагын архивын үйл ажиллагаа зэрэг уг үзүүлэлтээ сайжруулах | 2 сая | Архив, архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дүрэм журмын хэрэгжилтийн хувь | Архив, архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дүрэм журмын хэрэгжилт 90% | Архив, архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дүрэм журмын хэрэгжилт 90.5% | Цахим архив /Archiv.edoc/ системд 2022 оны Эрүүл мэндийн төвийн даргын А тушаал - 93, Б тушаал - 369, нийт 462 тушаалыг цахим архивт оруулсан.<br>Албан хэрэг хөтлөлтийн e.doc системийг бүрэн ашиглаж хэвшсэн.<br>2023 оны байдлаар нийт 575 албан бичиг ирсэн.<br>Үүнээс:<br>• Судалж байгаа 5<br>• Хариутай бичиг 130<br>• Шийдвэрлэлтийн дундаж хувь100%<br>• Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн бичиг байхгүй<br>• Хариутай, хариугүй бичгийн шийдвэрлэлтийн хувь-100%<br>Шуудан болон цахим хаягаар ирсэн албан бичгүүдийг e.doc системд бүрэн оруулж хэвшсэн.<br>Ирсэн бичгийн шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажилладаг.<br>Байгууллагаас edoc системээр явсан бүх бичгүүдийг тоон гарыг үсгээр баталгаажуулан явуулдаг.<br>2023 оны 05 сарын 18-ны өдөр Албан хэрэг хөтлөлтийн "Тоон гарын үсэг"-ийн гэрээг Монпасс Са ХХК-тай байгуулан хугацааг 2 жилээр сунган ажиллаж байна.<br>3.2023 оны 1 дүгээр улиралд нийт 153 баримт архивт хүлээн авч байгууллагын архивын нөхөн бүрдүүлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Үүнд:<br>• Байнга хадгалах -22,<br>• 50 жил хадгалах -39,<br>• Түр хадгалах -90,<br>• 70 жил хадгалах -2<br>Байгууллагын архивыг нөхөн бүрдүүлэх, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах талаар Баримт бичиг нягтлан шалгах комисс 2 удаа хуралдсан байна.<br>2023 онд нийт 23 иргэнд лавлагаа, хуулбар, цалингийн тодорхойлолт гаргаж өгсөн байна |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.1.4 | Магадлан итгэмжлэлийн хүний нөөцийн бодлого төлөвлөлтэй холбоотой хэрэгжилтийг хангаж ажиллах. | | Хэрэгжилт 90% | Хэрэгжилт 90% | Хэрэгжилт 90% | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын алба орон тооны гишүүд 2 , орон тооны бус 11, ХУЭМТөвийн чанарын багийн гишүүн 9, ӨЭМТ-ийн чанарын багийн гишүүн 15 нийт 37 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын алба нь Эрүүл мэндийн сайдын А/554 дүгээр тушаалын 3 бүлэг шалгуураар өөрийн үнэлгээг 5 тасаг нэгж, үзүүлж буй 27 тусламж үйлчилгээний чиглэл тус бүрээр хийж, бэлтгэл ажлыг хангасан. 2023 оны 1 дүгээр улиралд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн магадлан итгэмжлэлийн шинжээч нар магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтээр 2 удаа үнэлгээ хийсэн. Хан-Уул Эрүүл мэндийн төв нь ЭМС-ын 2023 оны 3 сарын 27-ны өдрийн А/108 дугаар тушаалаар 3 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдлээ. |
| 2.1.5 | Эмч, эмнэлгийн мэргэжилтний багц цаг бүрдүүлэлт хийх | | Багц цаг биелэлтийн хувь | Багц цагийн биелэлт 97,5% | Багц цагийн биелэлт 98 %. | Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг hr.hdc.gov.mn программд бүртгэн оруулж багц цагийн бүрдүүлэлтийг ханган ажиллуулж байна. 2023 оны байдлаар программд 126 эмч эмнэлгийн мэргэжилтэн бүртгэгдсэн. Эхний 11 сарын байдлаар 59 эмч 354 баг цаг, 42 сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн 126 багц цаг, 25 дээш жил ажилласан 19 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажлын тайлангаа бичээд байна. Лицензийн зөрчилтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн байхгүй байна. Багц цагийн биелэлт 100%-тай хэрэгжиж байна. |
| 2.1.6 | Гадаадын болон дотоодын мэргэжил дээшлүүлэх, нарийн мэргэжлийн сургалтад судалгаанд үндэслэн үе шаттай хамруулах | 10 сая | Гадаадын сургалтад-2, Дотоодын сургалт нийт-7 Мэргэжил дээшлүүлэх сургалтад-3 Төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтад-4 | Гадаадын сургалтад-2, Дотоодын сургалт нийт-7 Мэргэжил дээшлүүлэх сургалтад-3 Төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтад-4 | - | 2023 оны байдлаар гадаадын сургалтад 7 ажилтан хамрагдсан байна.Үүнд:<br>-Эм зүйн албаны дарга Д.Эрдэнэцэцэг Япон улсын Осако хотод "INTERPHEX OCAKO WEEK" ОУ-ын хурал семинарт,<br>- Геомодиализийн эмч Б.Намуунбайгаль Солонгос улсад зохион байгуулагдсан диализийн сургалт<br>-Хүний нөөцийн албаны дарга Ц.Энхбаясгалан Солонгос улсад зохион байгуулагдсан "Төрийн албаны удирдлага, манлайлал"<br>-Лабораторын эмч Д.Намуун-БНСУлсын Сувон хотод KSLM-LMCE 2023 Олон улсын хуралд,<br>-Хэт авиа оношлоогооны эмч Б.Цэндсайхан-Солонгос улсын Сөүл хотод болох Korean Congers of Radiology-2023 Олон улсын хуралдДурангийн сувилагч -Ч.Алтанцэцэг БНСУлсад "Сувилахуйн тусламж үйлчилгээ" сэдэвт сургалт<br>-Шүдний эмч Г.Төрбат БНСУлсад "Хиймэл шүдний оношилгоо, эмчилгээ" сэдэвт сургалтанд тус тус хамрагдсан.<br>Тус Эрүүл мэндийн төвөөс байгууллагын захиалгаар урт хугацааны сургалтанд<br>□ Арьс харшлын эмч З.Эрдэнэчимэг АӨСҮТөвд арьс судлалаар 2 жилийн хугацаагаар,<br>□ Хавдрын эмч Ц.Цэцэгмаа хавдрын хими эмчилгээгээр 6 сарын хугацаагаар<br>□ Дүрс оношлогооны эмч Г.Инжинаш эмэгтэйчүүдийн хэт авиа оношлогоогоор 3 сарын хугацаагаар суралцаж байна.<br>Мөн өөрийн хүсэлтээр<br>□ Мэдрэлийн эмч М.Нандинбаяр тархины судасны цахилгаан бичлэгээр 6 сарын хугацаагаар<br>□ Хэт авиа оношлогооны эмч Т.Дашмаа компьютер томографигаар 3 сарын хугацаагаар суралцаж байна.<br><br>2023 оны байдлаар байгууллагын захиалгаар<br>□ Эрчимт эмчилгээний эмч Ц.Түвшинбаяр<br>□ Халдвартын эмч Б.Намууцэцэг БЗДХ/ХДХВДОХ-ын эмчээр,<br>□ Мэс заслын эмч С.Дүйнхэржав андрологийн эмчээр<br>□ Мэдрэлийн эмч Г.Саруултуяа тархины судасны бичлэгийн эмчээр<br>□ Даатгалын эмч Б.Дэлгэрцэцэг статистикийн эмчээр<br>□ Дотрын эмч О.Баярнэмэх зүрх судасны эмчээр суралцаж төгсөөд ажиллаж байна. |
| 2.1.7 | Эмч, эмнэлгийн мэргэжилтний компьютерийн мэдлэг олгох сургалт, ehealth программын сургалтууд зохион байгуулна | Төсөв шаардахгүй | Сургалтанд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | Сургалт-2 Эмч,мэргэжилтэн - 68 | Сургалт-3 Эмч,мэргэжилтэн- 70 | Мэдээлэл технологийн албанаас e-health программын сургалтыг шинээр ажилд орсон эмч, сувилагч болон нийт эмч, сувилагч нарт тогтмол сургалт зохион байгуулж, e-health програмын талаар заавар, зөвлөмжийг тухай бүр өгч ажиллаж байна. 2023 оны байдлаар Эрүүл мэндийн төвийн үйлчилгээ түргэн, шуурхай зохион байгуулах, үйлчлүүлэгчийн хүлээгдэл, чирэгдлийг бууруулах зорилгоор E-Clinic системийн киоск машин үйлчилгээг нэвтрүүлснээр үзлэгийн цаг захиалах, эрүүл мэндийн хуудсыг хэвлэх, шинжилгээний хариуг шууд авах боломжтой болсон. Мөн энэхүү систем нь E-Mongolia систем болон эмнэлгийн дотоод удирдлагын системд шууд холбогдсон байна. 2023 онд нийт 19146 иргэний шинжилгээний хариуг 32477 хуудас шинжилгээний хариу хэвлэгдсэн мөн E-Health программаар 278050 иргэн үйлчлүүлсэн байна |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.1.8 | Удирдлага манлайлал чиглэлээр, дунд түвшний менежерүүдийг сургах | 2 сая | Сургалтад хамрагдсан тоо, хувь | Менежер 1 | Менежер-2 | Нийслэлийн Эрүүл мэндийн газраас харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх , чадавхжуулах, удирдахуйн ухаанаар мэргэшүүлэх зорилгоор Удирдлагын академитай хамтарсан мэргэшүүлэх сургалтанд Эрүүл мэндийн төвийн дарга Э.Бодьцэцэг хамрагдсан.<br><br>Удирдлага манлайлал чиглэлээр хүний нөөцийн албаны дарга Ц.Энхбаясгалан Солонгос улсад зохион байгуулагдсан "Төрийн албаны удирдлага, манлайлал" чиглэлээр сургалтанд хамрагдсан. |
| 2.1.9 | Эмч эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны сургалт | 2 сая | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт 95% | Төлөвлөгөөний хэрэгжилт 96% | Эрүүл мэндийн төвөөс байгууллагын ажилчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр гаргасан төлөвлөгөөний дагуу үе шаттай арга хэмжээг авч ажиллаж байна. Дотоодын 19 удаагийн сургалт зохион байгуулагдаж нийт 186 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Үүнд:<br>☐ Галын аюулгүй байдлын сургалтыг онцгой байдлын газартай хамтран "Галын аюулгүй байдал болон галын хор хэрхэн ашиглах тухай" 2 удаагийн сургалт<br>☐ Авлигатай тэмцэх газрын сургалт<br>☐ Эрүүл мэндийн төвийн дэргэдэх Ёс зүйн хэсгийн хорооны сургалт 2 удаа<br>☐ Хүний нөөцийн албанаас шинэ ажилтан чиглүүлэх 2 удаагийн сургалт<br>☐ Мэдээлэл технологийн албанаас e-health программын сургалт<br>☐ Хүний нөөцийн албанаас "Бичиг хэргийн стандарт" сэдэвт сургалт<br>☐ Грентологийн үндэсний төвөөс зохион байгуулагдсан "Настны эмийн зохистой хэрэглээ-амьдралыг чанар" сэдэвт сургалт<br>☐ "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай ойлголт" сэдэвт<br>Мөн Сонгдо эмнэлгээс тасралтгүй сургалтыг 8 удаа<br><br>☐ Чих хамар, хоолойн эмгэгүүдийн оношлогоо эмчилгээ<br>☐ Кетоацидозын үеийн оношлогоо эмчилгээ<br>☐ Бүсэлхий нурууны дискний ивэрхий болон нарийсал түүний оношлогоо эмчилгээ<br>☐ Бөөр шээсний замын мэс заслын оношлогоо эмчилгээ<br>☐ Бамбайн эмгэгийн оношилгоо, эмчилгээ, бамбайн хатгалт<br>☐ Дурангийн мэс заслын сүүлийн үеийн эмчилгээний аргууд<br>☐ Нүдний болор солих мэс засал<br>☐ Зүрхний хэм алдагдлуудын оношилгоо, эмчилгээ сэдвээр сургалтыг зохион байгуулсан. |
| 2.1.10 | Эмч эмнэлгийн мэргэжилтэн болон бусад төрийн албан хаагчид ёс зүйн хэсгийн хорооноос сургалт зохион байгуулах | 2 сая | Зохион байгуулсан сургалтын тоо | Зохион байгуулсан сургалтын тоо 2, нөлөөллийн ажлын тоо 2 350 албан хаагч | Зохион байгуулсан сургалтын тоо 3, нөлөөллийн ажлын тоо 2 360 албан хаагч | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, Эрүүл мэндийн Сайдын 2019 оны А/406 дугаар тушаал "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм"-ийн дагуу ёс зүйн дэд хороо үйл ажиллагаагаа явуулж байна. 2023 оны байдлаар байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 6 чиглэлээр мэдээ, мэдээллийг байршуулан ажилласан.<br>Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хуулийн танилцуулах сургалтыг 2 удаа, нөлөөллийн ажлыг 2 удаа, шинээр томилогдсон төрийн албан хаагчдад чиглүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. |
| Зорилт 2.2 Хүний нөөцийн ил тод байдал | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | Хүний нөөцтэй холбогдолтой болон МУЗГ, ЭМЯ, НЭМГ, харъяа дүүрэг түүний алба хэлтэсээс ирсэн дүрэм журам, тушаал заавруудыг дотоод групп, вэб сайтад байршуулж тухай бүрт нийт ажилтнуудаа мэдээллэж байна | Төсөв шаардахгүй | Биелэлтийн хувь | Биелэлт 98% | Биелэлт 98,5% | 2023 оны байдлаар хүний нөөцтэй холбогдолтой Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, харъяа дүүрэг түүний алба хэлтэсээс нийт 164 албан бичиг ирсэн байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар Төрийн захиргааны төв байгууллага, Нийслэл, дүүрэг, удирдах дээд шатны байгууллагаас ирсэн тушаал, шийдвэр нийт 35 байна. Үүнд:<br><br>-Эрүүл мэндийн сайдын албан даалгавар 5<br>- Эрүүл мэндийн сайдын тушаал 3<br>- Нийслэлийн Засаг даргын захирамж 5<br>- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын албан даалгавар 1<br>- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаал 11<br>- Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамж 8<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол 1<br>- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол 1<br>тус тус хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Байгууллагын дотоод сүлжээ болон вэб хуудсанд байршуулан, 14 хоногт тутам нэг удаа зохион байгуулагдаг эмч нарын яриан дээр дээд газраас ирсэн тушаал шийдвэр болон Эрүүл мэндийн төвөөс гарсан тушаал шийдвэрүүдийг тогтмол танилцуулан ажиллаж байна. |
| 2.2.2 | Нээлттэй ажлын байрны зарыг хөдөлмөр зуучлалын байгууллагууд болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайт, дотоод группт байршуулна | 1 сая | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт 97% | Үйл ажиллагааны хэрэгжилт 87% | Эрүүл мэндийн төв нь нээлттэй ажлын байрны зарыг байгууллагын вэб сайт, facebook сошиал хуудас, эрүүл мэндийн ажилтны нэгдсэн групп болон эмч, эмнэлгийн ажилтны зарын группт 14 хоног тутам байршуулан ажиллаж хэвшээд байна. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 24 удаа байршлуулснаас:<br>Дүрс оношлогооны эмч<br>□ Хэт авиа оношлогооны эмч-2<br>□ Эх барих эмэгтэйчүүдийн эмч<br>□ Хүүхдийн эмч<br>□ Уушигны эмч<br>□ Эмэгтэйчүүдийн эмч<br>□ Чих хамар хоолойн эмч<br>□ Гэмтлийн эмч<br>□ Хавдрын эмч<br>□ Даатгалын эмч-2<br>□ Дотоод шүүрлийн булчирхайн эмч<br>□ Эрчимт эмчилгээний эмч<br>□ Яаралтай тусламжийн эмч-3<br>□ Сүрьеэгийн эмч<br>□ Геомодиализийн эмч<br>□ Хөнгөвчлөх-хими эмчилгээний эмч<br>□ Эрүүл мэндийн нийгмийн ажилтан<br>□ Эх барих эмэгтэйчүүдийн бага эмч<br>□ Гэмтлийн сувилагч<br>□ Яаралтай тусламжийн сувилагч-2<br>□ Сэргээн засах эмчилгээний сувилагч<br>□ Дотрын эмч-2<br>□ Диализийн техникч<br>□ Цахим бүртгэлийн ажилтан<br>□ Лаборант-2<br>□ Ээлжийн сувилагч-3<br>□ Хөтөч-1<br>□ Үйлчлэгч-2 тус тус 39 хүнийг авч ажиллуулаад байна. |
| Зорилт 2.3 Нийгмийн баталгааг хангах, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.3.1 | Шинэчлэн батлагдсан байгууллагын "Хамтын гэрээ"-ний хэрэгжилтийг ханган ажиллана | Төсөв шаардахгүй | Хэрэгжилтийн хувь | Гэрээний хэрэгжилт 89% | Гэрээний хэрэгжилт 89% | Эрүүл мэндийн төв нь хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг үндэслэн эрүүл мэндийн төвийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороо харилцан тохиролцож 2022 оны 06 сарын 30-ны өдөр "Хамтын гэрээ"-г 2 жилийн хугацаатай байгуулсан. Хамтын гэрээнд цалин хөлс, нийгмийн баталгаа, дэмжлэг туслсамж, хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт, мэдлэг мэргэжил дээшлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, үйлдвэрчний эвлэлийн эрхийг хангах тухай, гэрээний хэрэгжилт, хяналт, хүлээх үүрэг хариуцлагыг тусган байгуулсан.<br><br>Хамтын гэрээг бүх эмч, ажилчдад танилцуулж гарын үсгээр баталгаажуулан шинээр ажилд орсон 42 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын байраа орхин явсан 2 ажилтныг захиргааны санаачлагаар ажлаас чөлөөлсөн. Мөн өндөр настны тэтгэвэрт гарсан 11 ажилтанд сарын цалинтай тэнцэх тэтгэмж, ар гэрийн гачигдал, эрүүл мэндийн шалтгаан, шинээр гэр бүл болоход 400.000 төгрөгийн тэтгэмжийг 8 ажилтанд олгоод байна. Хамтын гэрээнд заасны дагуу ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл, эрүүл зүйн шинжилгээ хийсэн тасгийн эрхлэгч, эмч, сувилагч, лаборант, техникч нарт үндсэн цалингийн 20-40 хүртлэх хувиар урамшуулал, үндэсний болон дэд хөтөлбөр хариуцсан эмч нарт улирал бүрт 30.000 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтанд хүүхдийн эмчилгээний зардалд зориулж жилд 1 удаа 500.000 төгрөгний мөнгөн тэтгэмжийг тус тус олгож ажилла байна. |
| 2.3.2 | Тайлант онд өндөр насны тэтгэвэрт гарч байгаа эмч, ажилчдыг эрүүл мэндийн тухай хуулийн дагуу мөнгөн тусламжинд хамруулах | 14 сая | Мөнгөн тусламж авсан эмч, ажилчдын тоо | Тэтгэвэрт гарах судалгааг үндэслэн 9 хүнд 1 сарын үндсэн цалингийн мөнгөн тэтгэмж олгосон. | Тэтгэвэрт гарах 12 албан хаагчын судалгааг гарган, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллана | 2023 оны байдлаар өндөр насны тэтгэвэрт гарсан 11 албан хаагч байна. Өндөр настны тэтгэвэрт гарч байгаа ажилчдын судалгааг тухай бүр гарган, Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу сарын үндсэн цалингийн мөнгөн тэтгэмж олгож Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2 дахь заалтын дагуу тэтгэмж авах албан бичгийг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлэн ажиллаж байна. |
| 2.3.3 | Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах /ЭМС-ын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/537 дугаар тушаалын гуравдугаар хавсралт/-ын дагуу | Байгууллагын төсөв | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилтийн хувь 86% | Хэрэгжилтийн хувь 90% | Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/537 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон бусад ажилчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд нийт 178 эмч, эмнэлгийн мэргэжилтэн буюу 95% нь хамрагдсан байна. Үүнээс В вирус-6, С вирус-14, MRSA-13, нөхөн үржих насны 111 эмэгтэй эмч, эмнэлгийн ажилтанд Torch-45, CA125-66 шинжилгээнд хамрагдсан. MRSA- илэрсэн 13 эмч, ажилчдыг халдвартын эмчтэй хамтран эмчилгээнд хамруулж, эмчлэн эрүүлжүүлэлт 100%-тай байна. Нөхөн үржих насны 5 эмэгтэй эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд эмчлүүлж, 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хоол боловсруулах эрхтэн тогтолцооны болон халдвартын эмчийн хяналтад хянагдаж байна.<br><br>Нийт албан хаагчдаас дараах шинжилгээнүүдийг авч байна.<br><br>☐ Кальци<br>☐ Эрдсийн шинжилгээг ( магни, кальци, натри, хлор) авч байна.<br><br>Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, арга хэмжээний хүрээнд Эм зүйн албанаас байгууллагын нийт 201 ажилтанд даралт бууруулах эм, витамин С-г олгоод байна. Мөн MRSA илэрсэн болон уушигны хатгалгаатай ажилчдыг эм тариагаар хангах зэрэг, эрүүлжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| 2.3.4 | Шинээр ажилд орсон ажилтанд зааварчилгаа өгөх, ажлын байранд дадлагажих, чиглүүлэх сургалтыг зохион байгуулна | Төсөв шаардахгүй | Тайлангийн хэрэгжилтийн хувь | Тайлангийн хэрэгжилт 93% | Тайлангийн хэрэгжилт 98% | 2023 оны 11 дүгээр сарын байдлаар Эрүүл мэндийн төвд шинээр ажилд орсон 42 албан хаагч байна.<br>Шинээр ажилд орсон эмч, ажилчдад ажлын байранд тусламж үйлчилгээ үзүүлэхэд ашиглах багаж тоног төхөөрөмж, хэрэгсэл, хөтлөгдөх анхан шатны маягтуудыг танилцуулан дадлагажих, чиглүүлэх сургалтыг явуулж байна. Шинээр орсон ажилтанд зааварчилгаа өгөх ажлын байрны сургалтыг 2 удаа зохион |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.3.5 | Эмч, ажиллагсдын ажиллах орчны талаар сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллах | Төсөв шаардахгүй | Нийт ажилчдын сэтгэл ханамжийн хувь | 129/86% | Сэтгэл ханамж 88% дээшлүүлнэ. | Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг хагас, бүтэн жилээр авч нэгтгэн, гарсан санал, хүсэлтийн дагуу ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Эмч, ажилчдын сэтгэл ханамжийн судалгаанаас гарсан дүнд тулгуурлан 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.Төвийн албан хаагчдыг эрүүл, аюулгүй, чанартай, халуун хоолоор хангах, ая тухтай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор кофе шопын үйл ажиллагаа 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нээж иргэд болон албан хаагчдыг ая тухтай, орчинд үйлчлүүлэх нөхцөл, бололцоог ханган ажиллаж байна. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нийт эмч, ажилчдыг ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаанд хамруулсан. Сэтгэл ханамжийн судалгаанд 169 эмч, ажилтан хамрагдсанаас ажилчдын сэтгэл ханамж 88.1%-тай байна. |
| 2.3.6 | Орон сууцжуулах хөтөлбөрт судалгаанд үндэслэн эмч, ажилчдыг хамруулах | 30 сая | Хөтөлбөрт хамргдсан ажилчдын тоо | 6 | 10 | Хан-Уул Эрүүл мэндийн төвийн нийт ажилчдаас орон сууцжуулах хөтөлбөрийн судалгааг авч 3 ажилтан материалаа бүрдүүлэн өгснөөс 1 сувилагчийн материал тэнцэж орон сууцжуулах хөтөлбөрт хамрагдахаар болсон. Эрүүл мэндийн яам Худалдаа хөгжлийн банктай Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсантай холбоотойгоор 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Худалдаа хөжлийн банкнаас Эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдад танилцуулга хийн, орон сууцны ипотекийн зээлэнд хамрагдахаар 15 ажилтан материалаа өгч судлуулснаас 6 ажилты зээл шийдвэрлэгдсэн байна. |
| 2.3.7 | Ажилчдын алжаал тайлах, амрах, хооллох өрөө гаргаж тохижуулах | 10 сая | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт 80 | Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг хагас, бүтэн жилээр авч нэгтгэн, гарсан санал, хүсэлтийн дагуу ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Эмч, ажилчдын сэтгэл ханамжийн судалгаанаас гарсан дүнд тулгуурлан 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Төвийн албан хаагчдыг эрүүл, аюулгүй, чанартай, халуун хоолоор хангах, ая тухтай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор кофе шопын үйл ажиллагаа 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нээж иргэд болон албан хаагчдыг ая тухтай, орчинд үйлчлүүлэх нөхцөл, бололцоог ханган ажиллаж байна. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар төвийн дотор засварын ажил дууссаны дараа эмч, эмнэлгийн ажилтнуудын алжаал тайлах, амрах өрөөг байгуулахаар төлөвлөж байна. |
| ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| Зорилт 3.1 Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. /НЗДҮАХ 2.1.6 ДЗДҮАМХ2.2.4, 2.2.5/ | | | | | | |
| 3.1.1. | 0-5 насны хүүхдэд хоол тэжээлийн цочмог дутлыг эрт илрүүлэн, А амин дэмээр ханган хамрагдалтыг нэмэгдүүлнэ | ЭМД ийн сан | Эрт илрүүлэлтийн хувь<br>А амин дэмийн хамралтын хувь | 0-5 насны хүүхдэд хоол тэжээлийн цочмог дутлын эрт илрүүлэг- 88 %<br>А витамин хамрагдалт 95% | 0-5 насны хүүхдэд хоол тэжээлийн цочмог дутлын эрт илрүүлэг- 89 %<br>А витамин хамрагдалт 97% | Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн статистик тоогоор дүүргийн хэмжээнд 0-5 насны 31,785 бүртгэлтэй бөгөөд давхардсан тоогоор 89594 хүүхдэд үзлэг хийсэн байна. 2023 оны 10 дугаар сарын байдлаар сууРь өвчтэй 26 хүүхэд диспансерийн хяналтад хянагдаж байна. Үүнд:Сульдаа -7, хоол тэжээлийн цочмог хүндэвтэр дутал -3, шүүдэст эмзэгшил -1, цус багадалт -5, жин багатай -10 хүүхэд байна. 2023 оны эхний 10 сарын байдлаар диспансерийн хяналтад байсан 76 хүүхдээс 50 хүүхэд буюу 66 % нь эдгэрч, эрүүлжсэн байна. 2023 оны 5.6-р сард 5 хүртэлх насны А аминдэм уувал зохих 27462 хүүхэд, уулгасан 26800 буюу 97% -ийг хамруулсан байна. Үүнээс: 6-11 сартай хамрагдвал зохих 5268 хүүхдээс 4926 /94%/ хүүхдэд , 12-59 сартай хамрагдвал зохих 22124 хүүхдээс 21874 /99 %/ хүүхдэд А аминдэм уулгасан байна.<br>Хоол тэжээлийн цочмог дутал илрүүлэг үзлэгт эхний 10 сарын байдлаар 13396 хүүхэд хамрагдсанаас хоол тэжээлийн цочмог хүндэвтэр дуталтай 3 хүүхдийг илрүүлэн эмчилгээнд хамруулан хяналтад, эцэг, эх, асран хамгаалагч нарт зөвлөмж зааварыг өгч ажилласан. 2023 оны 11 дүгээр сард хоол тэжээлийн цочмог дуталтай хүүхдийн эмчилгээнд хэрэглэгдэх самрын нухаш 4 хайрцаг 600 ширхэг, жигнэмэг 4 хайрцаг 1728 ширхэг НЭМҮТ -өөс хуваарилсныг Өрхийн эрүүл мэндийн төвүүд , хүүхдийн кабинетад тараан олголоо. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2 | 9,18,36 сартай хүүхдүүдийн өсөлт, хөгжилтийн хоцрогдолыг эрт илрүүлэх цогц үзлэгт сар бүр хамруулж үр дүнг тооцон ажиллах | ЭМД ийн сан | 9,18,36 сартай хүүхдийн өсөлт, хөгжилтийн хоцрогдол, бие сэтгэхүйн төрөлхийн болон олдмол гажиг илрүүлсэн хүүхдийн тоо, хувь | 18 сартай -464 хүүхэд хамрагдсан. 9.36 үзлэг хийгдээгүй | 9,18,36 сартай хүүхдүүдийн хоцрогдолыг эрт илрүүлэх цогц үзлэгийг сар бүр зохион байгуулж, үр дүнг тооцоно. | 2023 оны 2 дугаар сарын 16,17 -ны өдрүүдэд ӨЭМТ ийн 18 эмчийг "9. 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг" хийх сургалтад хамруулсан. 2023 оны 10 сарын байдлаар 9 ,18,36 сартай хүүхдийн хөгжлийн бэрхшээл илрүүлэх үзлэгт 9 сартай хамрагдвал зохих 2585 хүүхдээс 1511 буюу 58.4%, 18 сартай хамрагдвал зохих 2206 хүүхдээс 1030 буюу 47%, 36 сартай 2374 хүүхдээс 1244 буюу 52 %-ийг хамруулсан байна. Нийт 7165 хүүхдийн 3836 буюу 54% нь илрүүлэг үзлэгт хамрагдсан ба хөгжлийн хоцрогдолтой 2 хүүхдийг нарийн мэргэжлийн хүүхдийн эмчид илгээсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд илрээгүй байна. 2023 оны 9 сарын 6-наас ХУДЗДТГазрын 03/1364 тоот албан бичгийн дагуу 1 сарын хугацаатай" Хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх" аян зохион байгуулж,9.18.36 сартай хүүхдийн цогц үзлэгт хамрагдалтын хувийг 44%-иас 85.5 % болгосон .ЗДТГ -аас үзлэг хийхэд хэрэглэгдэх 4 гишгүүрт шат,9 ширхэг шоо,бөмбөг зэрэг 4.8 сая төгрөгийн хэрэглэгдэхүүнийг 15 өрхийн эрүүл мэндийн төвд олголоо. Мөн аяны хүрээнд Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хийсэн ажлыг дүгнэн, шагналт байр эзлүүлэн эхний 3 байрт шалгарсан эмнэлгүүдийг нийт 2.3 сая төгрөгөөр урамшуулсан. |
| 3.1.3 | Өсвөр насны хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг идэвхижүүлж шаардлагатай хүүхдүүдийг диспансерийн хяналтанд авч эрүүлжүүлэх | | Өсвөр насны хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын тоо | 1956 | 2100 | 2023 онд 3890 хүүхэд залууст тусламж үйлчилгээ үзүүлж зөвлөгөө өгөн ажилласан. Үүнээс амб-ын үзлэг 1768, урьдчилан сэргийлэх үзлэг-2122, Өсвөр насны 2896 хүүхэд залууст хар тамхи, мансууруулах бодисын хор уршгаас сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг явуулсан. Диспансерийн хяналтанд 37 хүүхэд аван хянаснаас18 хүүхэд эрүүлжин хасагдсан. 2 хүүхэд өөр дүүрэг /Баянзүрх,Сонгинохайрхан/ руу шилжсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгээр өвчтэй илэрсэн 276 хүүхдэд зөвлөгөө өгөн эмчлэн хянаж 146 хүүхэд буюу 52.8%-ийг эмчлэн эрүүлжүүлж эмчийн хяналтаас гарсан байна. |
| | | | Эрүүлжилт, хувиар | 48% | 50% | |
| 3.1.4 | Эх хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч жирэмсэн үеийн ургийн гажгийг эрт илрүүлэх, , урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх | ЭМД ийн сан | Чанарын шалгуур үзүүлэлт | Эхийн эндэгдэл -0, Төрөлхийн тэмбүү -0, хяналтгүй төрөлт-3, ЖСА-65% | Эхийн эндэгдэл -0, Хяналтгүй төрөлт, амьгүй төрөлт өмнөх оны мөн үеэс 1-2 тохиолдол буурсан.ЖСА-67% | 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй, хяналтгүй, гэрийн төрөлтийг магадлан хэлэлцэх хурлыг 2023.11.24-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга, хүүхэд өсвөр үеийн зохицуулагч, нөхөн үржихүйн зохицуулагч, эх барих эмэгтэйчүүдийн эмч нар, Хан-Уул нэгдсэн эмнэлгийн нөхөн үржихүйн зохицуулагч, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй хурлыг зохион байгууллаа. Хурлаар 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй, хяналтгүй, гэрийн төрөлтийн танилцуулга, цаашид авах арга хэмжээ, дүгнэлтийг танилцуулсан. 2023 оны эхний 9 сарын байдлаар<br>● Төрөлхийн тэмбүү-0<br>● Амьгүй төрөлт-11<br>● Хяналтгүй төрөлт-9<br>● Гэрийн төрөлт-2<br>● Эхийн эндэгдэл-1 /Хан-Уул нэгдсэн эмнэлэг/ байна.<br>Амьгүй төрөлтийн тохиолдол өмнөх оны мөн үеэс 9, эхийн эндэгдэл 1 тохиолдол, гэрийн төрөлт 3 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй боловч хяналтгүй төрөлт 9 тохиолдол бүртгэгдсэн байна. нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн Жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлийн хувь 68%-тай байна. |
| 3.1.5 | ДЗДТГ, ЭМТөв, Нэгдсэн эмнэлэг, Хорооны засаг дарга, ӨЭМТ-ийн дарга холбогдох эмч, мэргэжилтэнүүд хамтран "0-5 хүртлэх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдэл"-ийг бууруулах хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулна | 2 сая | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь 95% | Хан-Уул дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран 2023 оны 4-р улиралд хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна 2023 оны 7-р сард Дүүргийн засаг даргын А/380 дугаар захирамжаар "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн орон тооны бус салбар зөвлөл"-ийг 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, зөвлөлийн хурлыг 8-р сард хийж, хурлаар зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөг батлуулсан. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн орон тооны бус салбар зөвлөлийн хурлаар дүүргийн хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийн талаарх мэдээлэл хийж, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар танилцуулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.6 | Жирэмсэн эхийн нэрийн хяналт, жирэмсний хяналтын чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор "Жирэмсэн эмэгтэйн хяналт, бүртгэлийн програм-"ыг бүх жирэмсний хяналтын эмч, ӨЭМТ-дэд нэвтрүүлэн тусламж үйлчилгээний нэгдсэн хяналт зохицуулалтыг хэрэгжүүлж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх боломжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах | | Цахим програм нэвтрүүлсэн байгууллагын тоо<br>Эмч, мэргэжилтний тоо | ЭМТ-ийн болон ХУНЭ-ийн амбулаторийн жирэмсний хяналтын 5 эмч нэвтрүүлж эхэлсэн | ЭМТ, ХУНЭ-ийн жирэмсний хяналтын 7 эмч, 16 өрхийн эрүүл мэндийн төвүүд программыг бүрэн ашиглана | я<br>"Жирэмсэн эмэгтэйн хяналт, бүртгэлийн програм"-ыг бүх жирэмсний хяналтын эмч, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлэн тусламж үйлчилгээний нэгдсэн хяналт зохицуулалтыг хэрэгжүүлж, үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна. Нийт жирэмсний хяналтын-6 эмч, 16 өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар хяналтын програм ашиглаж байна. Баянзүрх дүүргийн эх барих эмэгтэйчүүдийн эмч нар , чанарын алба, мэдээлэл техноогийн алба, амулаторийн эрхлэгч нийт 15 эмч, мэргэжилтэн манай эрүүл мэндийн төвийн жирэмсний хяналтын програмын ашиглалт, нэвтрүүлсэн байдалтай танилцаж туршлага судалж үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| 3.1.7 | Жирэмсний хяналт, эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээнд ӨЭМТ -үүдийн оролцоог нэмэгдүүлж, эрт үеийн хяналтын хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | | Жирэмсний эрт үеийн хяналт, хувиар | 92% | 93% | 2023 оны эхний 11 сарын байдлаар жирэмсний хяналтад шинээр авсан эмэгтэйчүүдийн тоо-4598 үүнээс эхний 0-3 сартай хяналтад орсон эмэгтэйчүүдийн тоо- 4189 буюу жирэмсний эрт хяналтын хувь 91.1% байна. Хан-уул эрүүл мэндийн төвд-1091, өрхийн эрүүл мэндийн төвд 125, нэгдсэн эмнэлэгт-1061 буюу нийт 1234 жирэмсэн эхчүүд хянагдаж байна.<br>Жирэмсний хяналт, эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээнд хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтарч ажиллаж байна. Хувийн эмнэлэгт хянагдаж буй жирэмсэн эхчүүдийн судалгааг гаргахад:<br>• Интермэд эмнэлэгт-56<br>• Гурван гал -46<br>• Таны төлөө бид 5<br>• Тод дэлгэц 3<br>нийт 110 эх хянагдаж байна. |
| 3.1.8 | Нөхөн үржихүйн насны эрсдэлт, болон эмзэг бүлгийн эмэгтэйчүүд судалгаанд дүн шинжилгээ хийж, эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажиллана. | ЭМД ийн сан | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт 86% | Төлөвлөгөөний хэрэгжилт 88% | Дүүргийн хэмжээнд 61126 нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд байгаагаас:<br>• эрсдэлт бүлэг-2157<br>• эмзэг бүлэг-1503<br>• хөгжлийн бэрхшээлтэй-272 буюу зорилтот бүлэг нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 6.4%-г эзэлж байна<br>Эрсдэлт, эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн 2569/70%/-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан ба 2525 /69% / нь жирэмснээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж байна. |
| 3.1.9 | "Эх барих эмэгтэйчүүд"-ийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах аяныг зохион байгуулна | 300,000 | Аяны хэрэгжилтийн хувь | Аяны хэрэгжилт 98% | Аяны хэрэгжилт 98,5% | Дүүргийн хэмжээнд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах, эхийн эндэгдэл гарахаас сэргийлэх зорилгоор "нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулъя" сэдэвт 6 сарын аян зохион байгуулж, өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран аяны хүрээнд нийт 16 ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100% байна. |
| 3.1.10 | Бага насны хүүхдийн суурь өвчлөл, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэн, бүртгэх цахим хяналтын системийг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлэх ажлыг үе шаттай хийнэ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт 80% | Үйл ажиллагааны хэрэгжилт 85% | 2023 оны 1 дүгээр сард өрхийн эрүүл мэндийн төвийн хүүхэд хариуцсан 12 эмчид " Хоол тэжээлийн цочмог дутлын илрүүлэг үзлэг хийх, тайлан гаргах, эмчилгээнд хэрхэн хамруулах" сэдвээр сургалт зохион байгуулж арга зүйн зөвлөмж өгсөн.<br>GEREGE medtech " Хоол тэжээлийн цочмог дутал илрүүлэг систем"-тэй холбоотой мэдээллээр Эрүүл мэндийн төвийн мэдээлэл технологийн алба, хүүхдийн зохицуулагч эмч хамтран цахим сургалт зохион байгуулж 15 ӨЭМТ бүрэн хамрагдсан. Системийн хэрэгжилт, бүртгэл мэдээлэл 100%-ийн хэрэгжилттэй явагдаж байна.<br>2023 оны 8 дугаар сарын 17 нд Энхтитэм өрхийн эрүүл мэндийн төвд "Хоол тэжээлийн цочмон дутал илрүүлэг" системтэй холбоотой дэмжлэгт хяналт хийж тулгамдаж буй асуудлаар санал солилцон ажиллалаа.<br>2023 оны 10 сарын байдлаар Хоол тэжээлийн цочмог дутал илрүүлэг үзлэгт 13396 хүүхэд хамрагдсанаас хоол тэжээлийн цочмог хүндэвтэр дуталтай 2 хүүхдийг илрүүлэн эмчилгээний бэлэн хоол тэжээлийг 280 ширхэгийг олгон эмчийн хяналтад хянаж байна. |
| 3.1.11 | Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах. | - | Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | 2 удаагийн арга хэмжээ 35 иргэн | 2 удаагийн арга хэмжээ, 40 иргэн | Дүүргийн хэмжээнд 61126 нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд байгаагаас:<br>• эрсдэлт бүлэг-2157<br>• эмзэг бүлэг-1503<br>• хөгжлийн бэрхшээлтэй-272 буюу зорилтот бүлэг нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 6.4%-г эзэлж байна. хөгжлийн бэрхшээлтэй нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 70%-ийг 190 эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 85% буюу 231 эмэгтэйчүүдийг жирэмснээс сэргийлэх орчин үеийн аргад хамруулсан. |
| | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.12 | "Сайн туршлага-2023" шилдэг бүтээл шалгаруулах арга хэмжээг зохион байгуулна. Эмнэл зүйн сайн туршлагыг бүртгэн мэдээлэх, сурталчлах ажлыг өрнүүлнэ. | 550 | Аян зохион байгуулж шалгаруулсан байна. | 2022 онд 2 номинацид оролцож 2 шалгарсан | номинацийн төрлийг нэмэгдүүлсэн байна | Нийслэлийн Эрүүл мэндийн газраас 2023 оны 1 сараас эхлэн 7 хоног болгоны 4 дэх өдөр 16 цагаас "Сайн туршлага 2022" танилцуулах цахим хурал явагдаж эхэлсэн бөгөөд энэхүү цахим хуралд эрүүл мэндийн төвийн чанарын алба болон өрхийн менежер, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар ирцийг бүрэн хангаж оролцсоор байна. Нийслэлийн эрүүл мэндийн газрын 20 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 963 эмч, эмнэлгийн мэргэжилтэн сургалтанд оролцжээ. 2023 оны 4 сарын 13-ны өдөр "Сайн туршлага 2022 " – арга хэмжээнд шалгарсан 9 бүтээлийг Нийслэлийн хэмжээнд сурталчилан таниулах онлайн сургалтыг хийлээ. 5,7,9-р хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүд "Жирэмсэн үед хийх иог"-ийн дасгалыг 203 жирэмсэн эмэгтэйд хийж, сайн туршлагыг нэвтрүүлсэн. 2023 онд мэдээлэл технологийн чиглэлээр 2, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр 2 шинэ туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн 13 хүний бүрэлдэхүүнтэй баг манай эрүүл мэндийн төвийн "Жирэмсний хяналтын программ"-ыг судалж, туршлага судалж үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллахаар төлөвлөөд байна. Хан-Уул Эрүүл мэндийн төвийн Сайн туршлага 2023 арга хэмжээг 2023 оны 10 сарын 20-ны өдөр ЭМТҮЧАБ албанаас зохион байгууллаа. ХУЭМТ, 10 Өрхийн Эрүүл мэндийн төвийн 32 бүтээл оролцсоноос, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын "Сайн туршлага 2023" 2 дугаар шатны арга хэмжээнд 19 бүтээл шалгарав. Сайн туршлага 2023 арга хэмжээнд нийслэлийн 9 дүүргийн 220 бүтээл өрсөлдөв.<br>Хан-Уул Эрүүл мэндийн төвийн Сувилахуйн алба - Шинээр нэвтрүүлсэн сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад чиглэсэн технологи номинацид "Хөнгөвчлөх сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулах сургалтын хөтөлбөр" бүтээлээр Дэд байрын өргөмжлөл, мөнгөн шагнал<br>15-р хороо Мэндсаруул ӨЭМТ- Шинээр нэвтрүүлсэн оношилгооны технологи номинацид ""Оношилгооны төв", оношилгоонд хамрагдсан иргэдийн шинжилгээний дунд хийсэн судалгаа бүтээлээр Дэд байрын өргөмжлөл, мөнгөн шагнал<br>16-р хороо Энхбуянтманал ӨЭМТ- Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний технологи номинацид Цахимаар мэдээлэл солилцох дотоод чат групп бүтээлээр шилдэг хорин бүтээлийн гэрчилгээ<br>9-р хороо Аяут ӨЭМТ - Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний технологи номинацид "Kegel wellness room" Аарцаг ёроолын булчингийн чадамжийг сэргээх, хадгалахыг заах сургалтын өрөө бүтээлээр шилдэг хорин бүтээлийн гэрчилгээ, 19 батламжаар тус тус шагнуулсан байна. |
| 3.1.13 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж аюулгүй байдлыг сайжруулна | 25 сая | Зохион байгуулсан аян, өдөрлөгийн тоо | 3 аян зохион байгуулсан. | 3 аян, 3 өдөрлөг | Дэлхийн эмч нарын баярыг угтаж Эрүүл мэндийн төвийн эмч нарын дунд болзошгүй гамшгийн эрсдлийн үеийн бэлэн байдлыг хангаж ажиллах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэхэд багаар ажиллах ур чадварыг сайжруулах зорилгоор 3 сарын 25-ны өдөр "Ажил мэргэжлийн уралдаан" зохион байгуулсан 5 баг оролцож, эхний 3 байрыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.<br>"Сувилагчийн чадвар- Бидний бахархал" 14 хоногийн аяныг зарлаж 70 сувилагч оролцож өндөр үнэлгээ авсан эхний 5 сувилагчийг шагнаж урамшуулсан. |
| 3.1.14 | Спирограммын оношилгоог шинээр нэвтрүүлэх | ЭМД-ийн сан "Гүйцэтгэлээр " | Оношилгоонд хамрагдсан хүний тоо | оношилгохийгд ээгүй | Спирограммын оношлого 98 иргэн | 2023 онд 166 иргэнд спирометрийн шинжилгээ хийсэн. Үүнээс хэвтэн эмчлүүлэх тасагт 57 өвчтөнд хийсэний 17 иргэн амьсгал<br>бөглөрлийн хөнгөнөөс- хүнд зэргийн хам шинж 5 иргэнд илэрч оношилгоо, эмчилгээний зөвлөмжийг өгч ажиллаа. Амбулаториор үйлчлүүлж буй уушгины эмгэг асуумжтай 99 иргэний шинжилгээ хийсэний хяналтанд байдаг45 хүнд амьсгал бөглөрлийн өөрчлөлт илэрсэн. Мөн 10 үйлчлүүлэгч амьсгал бөглөрлийн дунд болон 1-р зэрэгийн өөрчлөлт илэрсэн байна.FEV1- амьсгал гаралтын сек/дэх хүчлэн гаргах амьсгалын эзлэхүүн 69%-60%-7 иргэн, 59%-50%- 2 иргэн, 35%-49%-1 иргэ. FVC-уушигний хүчилсэн амьдралын багтаамж 27 иргэнд хийсэн. Дээрх иргэдэд эмчилгээ зөвлөгөө өгч ажилласан. |
| 3.1.15 | Уламжлалт, Сэргээн засах өдрийн эмчилгээг нээж ажиллуулна. | ЭМД-ийн сан "Гүйцэтгэлээр " | Өдрийн уламжлалт, сэргээн засах эмчилгээг нээнэ | 2022 онд өдрийн эмчилгээ 65 хүн үйлчлүүлсэн | Өдрийн эмчилгээнд 100-150 иргэн | 2023 онд уламжлалт, Сэргээн засах өдрийн эмчилгээг нээсэн бөгөөд 102 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж зүү, төөнө, бариа, бумба, самнуур, цахилгаан, гэрэл, татлага, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, прафин, тан, талх, үрэл эмүүдээр эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн байна. Цаашид сэргээн засах өдрийн эмчилгээний нэр, төрөл нэмэгдүүлэх чиглэлд анхаарч байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.16 | Холтер 24 цагийн эмчилгээнд нэвтрүүлэх | "Гүйцэтгэлээр " | Холтер хийлгэсэн хүний тоо | 2022 онд холтер байхгүй | Холтер -160 | Онош тодруулах зорилгоор зүрхний эмгэгтэй иргэдэд холтер бичилгийг тогтмол хийж хэвшээд байна. Нийт 110 иргэнд зүрхний холтер бичлэг хийж эрүүл-60 хүн, синус брадикарди 10, синус тахикарди-14, синус синдром-17 хүн, AV block 1-р хэлбэр-4, AV 2-р хэлбэр-3, AV 3-р хэлбэр-1 илэрсэн байна. Өөрчлөлт илэрсэн 10 үйлчлүүлэгчийг 13А маягтаар 3-р шатлалын зүрхний хэм алдагдлын эмчид илгээж онош тодруулах, эмчилгээ, зөвлөмжийг өгч ажиллаж байна. |
| 3.1.17 | СӨБ болон ЕБС-ийн хүүхдүүдэд амны хөндийн гажиг засалын үзлэг, оношилгоо хийж үр дүнг тооцож, Эрүүл мэндийн боловсрол олгоно | ЭМД-ийн сан "Гүйцэтгэлээр " | Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо хувь. | 2500 хүүхдэд 3удаа үзлэг, 3 удаагийн сургалт | 2530 хүүхдэд 4 удаа үзлэг, 4 удаагийн сургалт | 2023 оны байдлаар амбулаториор шүдний үзлэгт 11265 хүүхэд, урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 18316 хүүхэд хамрагдаж нийт 29581 хүүхэд амны хөндийн үзлэг зөвлөгөө авсан байна. Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хүрээнд үзлэгт орсон хүүхдийн 60 % буюу 17748 хүүхэд амны хөндийн өвчлөлтэй байсан бөгөөд шүд цоорлоос урьдчилан сэргийлэх зорилгоор 1245 хүүхдэд фторт түрхлэгийг түрхэж багш, эцэг эх, асран хамгаалагч нарт амны хөндийн эрүүл мэнд, шүдээ хэрхэн угаах заавар, зөвлөмж өгсөн |
| 3.1.18 | Хөдөлмөрийн чадвар алдалт лист, Жирэмсний хуудас, Эмнэлэгт илгээх 13А маягтыг цахим хэлбэрт шилжүүлнэ | Төсөв шаардахгүй | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт 0 | Үйл ажиллагааны хэрэгжилт 60 хувь | Нэгдсэн цаг захиалгын 18000119, Үндэсний лавлах 19001109, Эрүүл мэндийн төвийн цахим бүртгэл 11341003, Эко киоск төхөөрөмж, E-Mongolia системүүдээс өөрийн сонголтоор цаг товлох үйлчилгээг авах боломжийг нээгээд байна. 2023 оны байдлаар цахим үйлчилгээнд цаг товлох үйлчилгээг 278050 иргэн, E-mongolia порталаар 26700 цаг тараагдсан, Шинжилгээний захиалга 349600 иргэн, 13А маягтыг 13349 иргэн, Цахим өвчний түүх 4484 нээсэн, Шинжилгээний хариу 311044 иргэн, Киоск төхөөрөмжөөс 17701 иргэн шинжилгээний хариу авсан, Hiep системд 5364 иргэний мэдээллийг бүртгэн 169566 иргэний үзлэг, шинжилгээг хадгалсан зэрэг үйлчилгээг үзүүлээд байна. |
| 3.1.19 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/396 дугаар тушаалаар батлагдсан Мэдээллийн аюулгүй байдлын журмыг хэрэгжүүлнэ. | Төсөв шаардахгүй | Мэдээллийн аюулгүй байдлын журамтай байна | Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны мэдээллийн аюулгүй байдлын журам | Мэдээллийн аюулгүй байдлын журмыг мөрдлөгө болгосон байна. | Төрийн болон албаны нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиуд, Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолын хүрээнд дээд шатны байгууллагаас ирсэн албан шаардлага, албан даалгавар, чиглэлийн хүрээнд Эрүүл мэндийн төвийн даргын А/48 дугаар тушаалаар төлөвлөгөө гарган ажиллаж байна |
| 3.1.20 | Иргэдэд зориулсан эмийн санг стандартын дагуу нээх хүсэлтийг хүргүүлж шийдвэрлүүлэх /Амбулаторийн үйлчлүүлэгчийн жорыг цахимаар илгээж эм зүйн тусламж үйлчилгээ, жорын хяналтыг хэрэгжүүлнэ/ | 100 сая | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Үйл ажиллагааны хэрэгжилт 0 | Үйл ажиллагааны хэрэгжилт 60 хувь | Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдэд зориулсан эмийн сан нээх хүсэлтийг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга хүлээн авах үйл ажиллагаатай холбоотой хойшилсон байгаа. Засварын ажил болон ЭМТ-ийн тусгай зөвшөөрлийн хугацаа солихтой холбоотой хойшилсон байгаа. Одоогийн байдлаар схем зураг тавилганы зураг зуруулж гүйцэтгэл 30% тай явагдаж байна. |
| ДӨРӨВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| Зорилт 4.1 Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд | | | | | | |
| 4.1.1. | 3 давхарын нийтийн бие засах өрөөний урсгал засвар | Байгууллагын төсөв | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт -0 | Хэрэгжилт 98% | 2023 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт 1,2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Эрүүл мэндийн төвийн дотор их засварын ажлын тендерт "Рок Гранд" ХХК шалгарч, засварын ажил 2023 оны 08 сарын 01-ний өдрөөс үйл ажилагаа явуулж байна. Засварын ажлын даалгаварын дагуу 2,3,4 дүгээр давхаруудын нийтийн бие засах өрөөнүүдийн засвар хийгдэж байна бэлэн болсон байна. |
| 4.1.2 | Тусламж үйлчилгээнд ашиглагдаж байгаа багаж тоног төхөөрөмжинд стандарт хэмжил зүйн төвөөр баталгаажуулалт хийлгэх | Байгууллагын төсөв | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт 98% | Хэрэгжилт 98,5% | 2023 оны 01 сарын 20-нд Стандарт, хэмжил зүйн газраар эмнэлгийн 10 ширхэг электрон жинд баталгаажуулалт хийлгэсэн.<br>Нисэх салбарын цэвэр усны тоолуурыг Ус суваг удирдах газрын лабораторит өгч 2029 он хүртэл баталгаажуулан, угсарч лацдуулсан.<br>2023 оны 5 сард Байгаль орчин хяналт зохицуулалтын газарт эрүүл мэндийн төвд ашиглаж байгаа хөргөгчний 7, өрөөний 8 ширхэг термометрт хэмжил зүйн баталгаажуулалт хийлгэсэн. |
| 4.1.3 | "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих арга хэмжээнд оролцон, мод тарих | Төсөв шаардахгүй | Тарьсан модны тоо | 2022 оны 5,10 сард 10 мод тарьсан байна. | "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрт оролцоно | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Эрүүл мэндийн ТТвийн хамт олны төлөөлөл "Denk Farm"-тай хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 45 ширхэг мод тарьж, усалгаа хийлээ. Мөн эрүүл мэндийн төвийн гадна фасад, гадна тохижилтын ажлын хүрээнд шинээр байгуулсан ногоон байгууламжинд 36 ширхэг мод бут тарьж, усалгааг хийсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.4 | УБ хотын Захирагчийн ажлын албанаас баталсан "Ердөө 90 минут" бүх нийтийн их цэвэрлэгээний гаргасан хуваарийн дагуу бүх нийтийн их цэвэрлэгээг хийж, тайланг илгээх | | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт 100% | Хэрэгжилт100 % | 2023 оны 01 дүгээр сарын 13, 02 дугаар сарын 17, 03 дугаар сарын 04, 04 дүгээр сарын 02, 07, 14, 05 дугаар сарын 26, 8 дугаар сарын 15, 10 дугаар сарын 27,11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд бүх нийтийн их цэвэрлэгээнд оролцож, орчны 50 метр талбайн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэсэн. Цэвэрлэгээнд нийт 304 эмч ажилчид оролцож, 5,5 тонн хог хаягдал, 150 мкв талбайн цас мөс, хог хаягдлыг цэвэрлэж ачуулсан.Мөн байгууллагын гадна орчны хайс, хашлага, шат довжоо,сандал, хогийн сав, гадна хаягийг 2 удаа угааж, хүлээлгийн 4 сандал, 2 хогийн савыг будсан. Гадна тохижилтын ажлын хүрээнд шинээр 6 хогийн сав байршуулсан. |
| Зорилт 4.2 "Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн"-ийн хүрээнд | | | | | | |
| 4.2.1 | Байгууллагын алба хаагчдын жендэрийн чиглэлээр статистикийн мэдээллийн нэгдсэн сантай болох, хүйсээр ангилсан тоон тайлангийн хэрэглээг нэвтрүүлэх | Төсөв шаардахгүй | Мэдээлэлийн сантай болсон байна | Алба хаагчдын нэгдсэн судалгаатай боловч хүйсийн харьцааны харьцуулсан судалгаа байхгүй | Сүүлийн 3 жилийн хүйсийн харьцааны нарийвчилсан судалгааг гаргасан байна. | Эрүүл мэндийн төвийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн судалгааг жил бүр гарган, хүйсээр ангилсан тоон мэдээ, судалгааны нэгдсэн санг үүсгэн ажиллаж байна.<br>Тус эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 224 эмч, эмнэлгийн ажилтнаас эрэгтэй 21, нийт ажилчдын 9.3%, 2022 онд нийт 208 эмч, эмнэлгийн мэргэжилтнээс эрэгтэй-24, нийт ажилчдын 11.5%, 2023 онд нийт 214 эмч, эмнэлгийн мэргэжилтнээс эрэгтэй-27 нийт ажилчдын 12.6%-ийг эзэлж байна.<br>Нэгдсэн эмнэлгийн бүтэц MNS 5095-2017 стандартад нийцүүлэн эмч, эмнэлгийн ажилчдын зохистой харьцаанд анхаарч ажиллаж байна. |
| 4.2.2 | Эмч, ажилчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана /ҮХ2.1/ | Аж ахуй нэгж байгууллага, | Зохион байгуулсан сургалт,хамрагдсан албан хаагчийн тоо | 2 удаагийн сургалтад 11 албан хаагч хамруулсан | 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 265 албан хаагч хамруулна | Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, авилгатай тэмцэх "шүгэл, шүүр, шувуу, шилжүүлэн авах, шил" ажиллагааг хэрэгжүүлэхээр тогтсон.<br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 03 сарын 17-ны өдрийн ХЭГ/595 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгийг нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>"Авлигатай тэмцэх жил"-ийн аяны мэдээ мэдээллийг вэб хуудсанд, албан хаагч нарт танилцуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй "МЭДЬЕ, НЭГДЭЕ" аяны хүрээнд иргэдэд төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх чиглэлээр Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 10 сарын 16-ны А/66 дугаар тушаалаар сарын аяны төлөвлөгөө гарган Хан-Уул Эрүүл мэндийн төвийн албан хаагч, үйлчлүүлэгч нарт иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгаа, албан хаагч нарт сургалт, ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлж, мэдээлэх соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаа. Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр "МЭДЬЕ, НЭГДЭЕ" аяны хүрээнд "Шударга бус зүйлд үгүй гэж хэлье" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 46 ажилтан хамрагдлаа. |

ХЯНАСАН: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОРЛОГЧ ДАРГА.................................Д.ГЭЖИЙМАА

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ ДАРГА.........Т.БУЛГАНТАМИР